



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
НЯМ-ОСОРЫН УЧРАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025.11.25 № 35-1/135
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар яаралтай хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт хуудастай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР

000254005770



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.11.25 № ХЭГ/3300
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай**

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хавсралт *66*. хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000355017817

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 27 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“2.ХЭЛЭЛЦСЭН нь: Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.11.24 № 1/2363

танай 2025.11.12 -ны № 01/3241 -т

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙД Г.ДАМДИННЯМ ТАНАА

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

 Б.ЭНХБАЯР

151602079 А5 файл/2025



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.11.24 № 1/2364
танай 2025.11.12 -ны № 01/3242 -т

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙД Г.ДАМДИННЯМ ТАНАА

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19^{1.1} дэх хэсэгт зааснаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.



Б.ЭНХБАЯР

151603074
АБ, файл.2025



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2025.11.25 № 01/10391

танай _____-ны № _____-т

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД Г.ДАМДИННЯМ ТАНАА

Стратегийн ач холбогдол бүхий
бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих
тухай хуулийн төсөл болон холбогдох материалтай
танилцаад Хууль тогтоомжийн тухай хуулийн 20
дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн
Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг
үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн

Б.ЖАВХЛАН

9761002206



СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХАНГАМЖ, НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах нь дараах үндэслэлтэй байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн¹ тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн² 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Засгийн газар нь эдийн засгийн харилцааг аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийн сонирхолд нийцүүлэн зохицуулж, шударга өрсөлдөөнийг дэмжин дангаар ноёрхлыг хязгаарлах, эдийн засгийн тэнцвэрийг сайжруулах арга хэмжээ авна.” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.” гэж;

2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор³ баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.9-д Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна.” гэж;

3. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 98 дугаар тогтоолоор баталсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн 4.3.2-т “Евро-5” стандартад нийцсэн чанарын шаардлага хангасан шатахууны импорт, хэрэглээг дэмжих, стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг импортоор оруулах, хэрэглэхийг үе шаттайгаар хориглох, шатахууны чанарын хяналтын тогтолцоог сайжруулах; гэж, Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийн 5.2-ын 118-д “Евро-5” стандартад нийцсэн шатахууны эзлэх хувийг 2025 онд 80 хувьд хүргэнэ,” гэж;

4. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992 он, №01

² Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1993 он, №03

³ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2024 он, №35

чиглэл"-д Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 4.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно” гэж, тус тус заасан нь хуулийг төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

1.2.Практик шаардлага

Өнөөдрийн байдлаар манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд нийт импортын 95 орчим хувийг ОХУ, үлдсэн хувийг БНХАУ эзэлж байна.

Улс орны нийгэм, эдийн засаг, уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлттэй холбоотойгоор манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа бөгөөд 2023 онд 2.4 сая тонн, 2024 онд 2.8 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн тус тус импортлон хэрэглэж байсан бол 2025 оны 9 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар импортын хэмжээ 2.2 сая тонн болж өмнөх оноос даруй 21,0 хувиар өссөн дүнтэй байна.

Манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын Засгийн газар болон нийлүүлэгч компаниудаас тус улсын дотоодын зах зээлийн нөхцөл байдал, үйлдвэрийн процесс, төлөвлөгөөт ажилтай холбоотойгоор гаргасан экспортын хориг, нийлүүлэлтийг бууруулах зэрэг арга хэмжээнүүд нь манай улсын шатахууны хангамжийн тогтвортой байдалд шууд нөлөөлж, тасалдал хомсдол үүсгэн, эрэлтийг нэмэгдүүлэн, үнийн хэлбэлзлийг бий болгож ирсэн. Тухайлбал, 2021 оны 10 дугаар сард ОХУ-ын Роснефть компани АИ-92 автобензинийн сарын нийлүүлэлтийг бууруулсантай холбоотойгоор дотоодын зах зээл дээр АИ-92 автобензинийн нийлүүлэлт тасалдсан, мөн ОХУ-ын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр 1537 дугаар тогтоолоор шатахууны экспортыг түр хугацаанд хориглосны улмаас Монгол Улс руу ачигдах газрын тосны бүтээгдэхүүний тээвэрлэлт зогсож, нийт 21 хоногийн хугацаанд импорт хийгдээгүйгээс шалтгаалан дотоодын зах зээл дээр түлш, шатахууны хангамж тасалдах, доголдох эрсдэлүүд тулгарч ирсэн.

Түүнчлэн, иргэдийн өргөн хэрэглээний АИ-92 автобензинийн хэрэглээ 2024 онд сард дунджаар 60,0 мянган тонн байсан бол 2025 онд сард дунджаар 80 мянган тонн хүрээд байна. Одоогоор ОХУ-ын “Роснефть” компанитай хийсэн хэлэлцээр, гэрээний хүрээнд 705,0 ам.долларын тогтмол үнээр нийлүүлж буй энгийн АИ-92 автобензинийн хэмжээ нь 60,0 мянган тонноор хязгаарлагдаж, нэмэгдүүлэх боломжгүй нөхцөл байдалтай байна. Үлдсэн 20,0 мянган орчим тонн Евро-5 ангиллын АИ-92 автобензинийг БНХАУ-аас олон улсын зах зээлийн үнээр худалдан авахаас аргагүй байдал үүсээд байна.

Иймд шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангахтай холбогдуулан улсын хэмжээнд 30-аас доошгүй хоногийн тогтмол нөөцтэй байх зорилтын хүрээнд импортлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, нөөцийг бүрдүүлэх, хадгалах савны хүчин чадал, багтаамжийг нэмэгдүүлэх, бодит шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэ хуулийн төсөл нь олон улсын худалдааны нөхцөл байдал, гадаад хүчин зүйлээс сэргийлэх, стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, даван туулах арга хэмжээг тодорхойлох, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилт, холбогдох хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн зарчмын талаар тусгах бөгөөд эдгээр зохицуулалтын гол зорилго нь стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжихэд чиглэнэ;

Хоёрдугаар бүлэгт Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд тусгагдаагүй төрийн байгууллагуудын авч хэрэгжүүлэх онцлог зохицуулалтыг тусгана.

Тухайлбал, Засгийн газар стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хэмжээг нийлүүлэгч талаас 50 болон түүнээс дээш хувиар бууруулсан тохиолдолд дотоодод шатахууны нийлүүлэлтэд хомсдол, тасалдал үүсэх нөхцөл бүрдсэн гэж үзэж нийлүүлэлтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авах бөгөөд улмаар шуурхай штаб байгуулж, импортлогч аж ахуйн нэгжүүдийн бөөний агуулахад хяналт тавих, импортын шатахууныг хуваарилах, жижиглэнгээр түгээх, борлуулах хэмжээг тогтоох ажлыг шуурхай зохион байгуулах;

Түүнчлэн, шаардлагатай тохиолдолд онцгой байдлын болон батлан хамгаалах салбарт хадгалагдаж байгаа нөөцийг гаргах;

Зохион байгуулалтын шинжтэй дээрх зохицуулалтаас гадна Монголбанк стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих, валютын нөөцийг нэмэгдүүлэх, гадагш урсгалыг бууруулах зорилгоор аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгөд шаардагдах хөнгөлөлттэй санхүүжилтийг репо арилжааны нөхцөлөөр банканд олгох, мөн хадгалах агуулах, шилжүүлэн ачих байгууламж, дэд бүтцийг шинээр барих, өргөтгөхөд шаардагдах санхүүжилтийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, эсхүл гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авах зэрэг зохицуулалтыг тусгана.

Гуравдугаар бүлэгт хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хуулийн үйлчлэх хугацааг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл батлагдсанаар газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамж тогтворжих, гадаад дотоод хүчин зүйлсээс шалтгаалан үүсэх газрын тосны бүтээгдэхүүний тасалдал, хомсдолоос урьдчилан сэргийлэх, хомсдолоос үүсэх эрсдэлийг бууруулах, газрын тосны бүтээгдэхүүний агуулахын хүчин чадал нэмэгдэх, авто тээврийн хэрэгслээс ялгарах агаарын бохирдол бууруулах, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогод тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлт хангагдах, нийгэм эдийн засгийн өсөлтийг дэмжих зэрэг чухал ач холбогдолтой юм.

Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал;

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулах бөгөөд дагалдуулан боловсруулах хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.

-oOo-

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл

Энэ хуулийн төсөл нь олон улсын худалдааны нөхцөл байдал, гадаад хүчин зүйлээс сэргийлэх, стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, даван туулах арга хэмжээг тодорхойлох, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой.

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилт, холбогдох хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн зарчмын талаар тусгах бөгөөд эдгээр зохицуулалтын гол зорилго нь стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжихэд чиглэнэ.

Хоёрдугаар бүлэгт Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд тусгагдаагүй төрийн байгууллагуудын авч хэрэгжүүлэх онцлог зохицуулалтыг тусгана.

Тухайлбал, Засгийн газар стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хэмжээг нийлүүлэгч талаас 50 болон түүнээс дээш хувиар бууруулсан тохиолдолд дотоодод шатахууны нийлүүлэлтэд хомсдол, тасалдал үүсэх нөхцөл бүрдсэн гэж үзэж нийлүүлэлтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авах бөгөөд улмаар шуурхай штаб байгуулж, импортлогч аж ахуйн нэгжүүдийн бөөний агуулахад хяналт тавих, импортын шатахууныг хуваарилах, жижиглэнгээр түгээх, борлуулах хэмжээг тогтоох ажлыг шуурхай зохион байгуулна.

Түүнчлэн, шаардлагатай тохиолдолд онцгой байдлын болон батлан хамгаалах салбарт хадгалагдаж байгаа нөөцийг гаргах юм.

Зохион байгуулалтын шинжтэй дээрх зохицуулалтаас гадна Монголбанк стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих зорилгоор аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгөд шаардагдах хөнгөлөлттэй санхүүжилтийг репо арилжааны нөхцөлөөр банканд олгох, мөн хадгалах агуулах, шилжүүлэн ачих байгууламж, дэд бүтцийг шинээр барих, өргөтгөхөд шаардагдах санхүүжилтийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, эсхүл гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авах зэрэг зохицуулалтыг тусгана.

Гуравдугаар бүлэгт хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хуулийн үйлчлэх хугацааг тусгана.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын тогтоол болон бусад хуультай нийцтэй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Засгийн газар нь эдийн засгийн харилцааг аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийн сонирхолд нийцүүлэн зохицуулж, шударга өрсөлдөөнийг дэмжин дангаар ноёрхлыг хязгаарлах, эдийн засгийн тэнцвэрийг сайжруулах арга хэмжээ авна.” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.


Олон улсад үүсэж байгаа худалдааны тарифын тодорхойгүй нөхцөл байдал нэмэгдэхийн зэрэгцээ Америкийн Нэгдсэн Улсын худалдааны тарифын бодлого, зарим улс оронд болж байгаа тусгай арга хэмжээтэй холбоотойгоор дэлхийн худалдаа, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэж байна.

Дээрх нөхцөл байдлын улмаас манай улсын экспортын зарим бүтээгдэхүүний үнэ, эрэлт буурах эрсдэл үүсэж, улмаар экспортын орлого буурах, гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн болох газрын тосны үнэ, нийлүүлэлт тогтворгүй байгаа зэргээс шалтгаалан төлбөрийн тэнцэлд дарамт үзүүлж болзошгүй нөхцөл байдал үүсээд байна.

Түүнчлэн тарифын өсөлт, худалдааны зөрчил, зарим улс оронд болж буй тусгай арга хэмжээ зэрэгтэй холбоотой дэлхийн улс орнуудад инфляц өсөх эрсдэлтэй байгаа нь манай улсын импортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ өсөх, бодлогын хүү өндөр түвшинд хадгалагдах эрсдэлтэй байгаа нь гадаад санхүүжилтийн өртөг, зардлыг нэмэгдүүлж улмаар төлбөрийн тэнцэлд дарамт үзүүлэхээр байна.

Иймд олон улсад өрнөж байгаа худалдааны болон тарифын бодлого зохицуулалтын өөрчлөлт, зарим улс оронд болж буй тусгай арга хэмжээ зэрэг арга хэмжээний сөрөг нөлөөллөөс үндэсний эдийн засаг, санхүүгийн байдлаа хамгаалах, төлбөрийн тэнцлийг хангах, эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулах, хямралаас сэргийлэх, болзошгүй эрсдэл хохирлыг бууруулах, нийгэм-эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн шийдвэрийг угтуулан тооцон гаргаж, эрх зүйн зохицуулалт хийх нь зүйтэй байна.

Шатахууны хил үнэ 2022-2024 он (ам.доллар/тонн)



Оросын Холбооны Улсаас манай улсад нийлүүлэх шатахууны импортын хил үнэ нь дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэтэй шууд хамааралтай байдаг бөгөөд хил үнэ нь дотоодын зах зээл дээрх борлуулалтын үнийг тодорхойлдог.

Өнөөдрийн байдлаар манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд нийт импортын 95 орчим хувийг ОХУ, үлдсэн хувийг БНХАУ эзэлж байна.

Улс орны нийгэм, эдийн засаг, уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлттэй холбоотойгоор манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж ирсэн бөгөөд 2023 онд 2.4 сая тонн, 2024 онд 2.8 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн тус тус импортлон хэрэглэж байсан бол 2025 оны 9 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар импортын хэмжээ 2.2 сая тонн болж өмнөх оноос даруй 21 хувиар өссөн.

Газрын тосны бүтээгдэхүүний импорт /мян.тонн/



Цаашид уул уурхай, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, нийгэм, эдийн засгийн өсөлтийг дагаад манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ тасралтгүй өсөн нэмэгдэж, 2026 онд 2.8 сая тн, 2027 онд 2.9 сая тн-д хүрэх төлөвтэй байна.

Манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын Засгийн газар болон нийлүүлэгч компаниудаас тус улсын дотоодын зах зээлийн нөхцөл байдал, үйлдвэрийн процесс, төлөвлөгөөт ажилтай холбоотойгоор гаргасан экспортын хориг, нийлүүлэлтийг бууруулах зэрэг арга хэмжээнүүд нь манай улсын шатахууны хангамжийн тогтвортой байдалд шууд нөлөөлж, тасалдал хомсдол үүсгэн, эрэлтийг нэмэгдүүлэн, үнийн хэлбэлзлийг бий болгож ирсэн. Тухайлбал, 2021 оны 10 дугаар сард ОХУ-ын Роснефть компани АИ-92 автобензинийн сарын нийлүүлэлтийг бууруулсантай холбоотойгоор дотоодын зах зээл дээр АИ-92 автобензин тасалдсан, мөн ОХУ-ын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 1537 дугаар тогтоолоор шатахууны экспортыг түр хугацаанд хориглосны улмаас Монгол Улс руу ачигдах газрын тосны бүтээгдэхүүний тээвэрлэлт зогсож, нийт 21 хоногийн хугацаанд импорт хийгдээгүйгээс шалтгаалан дотоодын зах зээл дээр түлш, шатахууны хангамж тасалдах, доголдох эрсдэлүүд тулгарч ирсэн.

Иймд газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдэд шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангахад шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний нэг сар (30 хоног)-аас доошгүй

хэрэглээний нөөцийг хадгалах агуулах барихад шаардагдах хөнгөлөлттэй санхүүжилтийг олгох асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Энэ хуулийн төсөл нь олон улсын худалдааны нөхцөл байдал, гадаад хүчин зүйлээс сэргийлэх, стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, даван туулах арга хэмжээг тодорхойлох, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой.

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилт, холбогдох хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн зарчмын талаар тусгасан бөгөөд эдгээр зохицуулалтын гол зорилго нь стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжихэд чиглэнэ.

Хоёрдугаар бүлэгт Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд тусгагдаагүй төрийн байгууллагуудын авч хэрэгжүүлэх онцлог зохицуулалтыг тусгасан.

Тухайлбал, Засгийн газар стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хэмжээг нийлүүлэгч талаас 50 болон түүнээс дээш хувиар бууруулсан тохиолдолд дотоодод шатахууны нийлүүлэлтэд хомсдол, тасалдал үүсэх нөхцөл бүрдсэн гэж үзэж нийлүүлэлтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авах бөгөөд улмаар шуурхай штаб байгуулж, импортлогч аж ахуйн нэгжүүдийн бөөний агуулахад хяналт тавих, импортын шатахууныг хуваарилах, жижиглэнгээр түгээх, борлуулах хэмжээг тогтоох ажлыг шуурхай зохион байгуулах юм.

Түүнчлэн, шаардлагатай тохиолдолд онцгой байдлын болон батлан хамгаалах салбарт хадгалагдаж байгаа нөөцийг гаргах асуудлыг шийдвэрлэнэ.

Зохион байгуулалтын шинжтэй дээрх зохицуулалтаас гадна Монголбанк стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих зорилгоор аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгөд шаардагдах хөнгөлөлттэй санхүүжилтийг репо арилжааны нөхцөлөөр банканд олгох, мөн хадгалах агуулах, шилжүүлэн ачих байгууламж, дэд бүтцийг шинээр барих, өргөтгөхөд шаардагдах санхүүжилтийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, эсхүл гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авах зэрэг зохицуулалтыг тусгана.

Гуравдугаар бүлэгт хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хуулийн үйлчлэх хугацааг тусгана.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын тогтоол болон бусад хуультай нийцтэй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХАНГАМЖ, НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь олон улсын худалдааны нөхцөл байдал, гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан дотоодын зах зээл дээр стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг дэмжих, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, даван туулах арга хэмжээг тодорхойлох, холбогдох шийдвэрийг шуурхай гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Стратегийн ач холбогдол бүхий зарим бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих хууль тогтоомж

2.1.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь олон улсын хүрээнд өрнөж буй худалдааны болон тарифын зохицуулалт, бусад зөрчилдөөн бүхий асуудлуудын сөрөг нөлөөллөөс дотоодын эдийн засгийг хамгаалах, аюулгүй байдлыг бэхжүүлэх, Монгол Улсын дотоод нөхцөл байдлаас үл хамаарах нөхцөл, шалтгаанаас улбаатай стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих асуудлыг зохицуулах бөгөөд энэ хуульд зохицуулснаас бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Үйл ажиллагаанд баримтлах зарчим

4.1.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

- 4.1.1.үндэсний язгуур ашиг сонирхлыг эрхэмлэх;
- 4.1.2.гадаад худалдааны алдагдлыг бууруулах, худалдааг хөнгөвчлөх;
- 4.1.3.шуурхай, хариуцлагатай байх;
- 4.1.4.шударга, ил тод байх.

5 дугаар зүйл.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн

5.1. Энэ хуулийн 3.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүнд керосин, дайвар бүтээгдэхүүнээс бусад газрын тосны бүтээгдэхүүн, бүх төрлийн шатахууныг ойлгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

6 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

6.1.Монгол Улсын Их Хурал стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжихтэй холбоотой бодлого, хууль тогтоомжийн төслийг яаралтай горимоор хэлэлцэх;

6.1.2.стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд хяналт тавих.

7 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

7.1.Засгийн газраас газрын тосны бүтээгдэхүүний гадаад захиалга, нийлүүлэлтийн хэмжээг нийлүүлэгч тал 50, түүнээс дээш хувиар бууруулсан тохиолдолд дотоодод бүтээгдэхүүний хомсдол, тасалдал үүсэх нөхцөл бүрдсэн гэж үзэж дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.газрын тосны бүтээгдэхүүний гадаад эх үүсвэр, захиалга, нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх;

7.1.2.гадаад эх үүсвэр, захиалга, нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх талаар хөрш орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан шуурхай арга хэмжээг авах;

7.1.3.газрын тосны бүтээгдэхүүний импортлогч аж ахуйн нэгжүүдийн бөөний агуулахад хяналт тавих, түгээх ажлыг шуурхай зохион байгуулах;

7.1.4.энэ хуулийн 7.1.3-т заасан чиг үүргийн хүрээнд импортын бүтээгдэхүүнийг хуваарилах, жижиглэнгээр түгээх, борлуулах хэмжээг тогтоох;

7.1.5.шаардлагатай тохиолдолд Улсын нөөцийн тухай хуулийн 13.1.4-т заасан арга хэмжээг яаралтай горимоор хэлэлцэж, шийдвэрлэх;

7.1.6.батлан хамгаалах салбарт хадгалагдаж байгаа нөөцийг зарцуулах асуудлыг яаралтай горимоор хэлэлцэн шийдвэрлэх;

7.1.7.энэ хуулийн 7.1.5, 7.1.6-д заасны дагуу нөөцөөс зарцуулсан бүтээгдэхүүнийг нөхөн бүрдүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

7.1.8.энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаар, Өрийн удирдлагын тухай хуулийн шаардлагын хүрээнд Засгийн газрын өрийн баталгаа гаргах.

7.2.Засгийн газар нь энэ хуулийн 7.1-д заасан нөхцөлөөс үл хамааран төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний хангамж, хяналтын системийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

7.3.Энэ хуулийн 5.1-д заасан Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих аж ахуйн нэгжийг сонгох шалгуурыг тодорхойлон, хүлээх үүрэг, хариуцлагыг тусгасан гэрээг аж ахуйн нэгжтэй байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих, биелэлтийг холбогдох салбарын төрийн захиргааны төв байгууллага хангуулан ажиллах үүрэгтэй.

8 дугаар зүйл.Монголбанкны бүрэн эрх

8.1.Монголбанк энэ хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.газрын тосны бүтээгдэхүүний импортын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгөд шаардагдах хөнгөлөлттэй санхүүжилтийг репо арилжааны нөхцөлөөр банканд олгох;

8.1.2.газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор хадгалах агуулах, шилжүүлэн ачих байгууламж, дэд бүтцийг шинээр барих, өргөтгөхөд шаардагдах санхүүжилтийг репо арилжааны нөхцөлөөр олгох, эсхүл гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээг авах.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд банкнаас зээл олгоход тавигдах зохистой харьцааны болон бусад шалгуур үзүүлэлт, зээлийн шаардлага, нөхцөлийг тусгайлан тогтооно.

8.3.Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан арга хэмжээг авахад Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 5, 7 дахь заалт хамаарахгүй.

9 дүгээр зүйл.Орон нутгийн төрийн захиргааны байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээ

9.1.Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжихтэй холбогдуулан харьяа нутаг дэвсгэртээ газрын тосны бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үйл ажиллагааг дэмжих, аливаа хэлбэрээр саад учруулах нөхцөл байдал үүсгэхгүйгээр ажиллах үүрэгтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

10 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

10.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

10.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

11 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хугацаа

11.1.Энэ хууль 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд үйлчилнэ.

ГАРЫН ҮСЭГ

**СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ХАНГАМЖ, НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН
ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

АГУУЛГА:

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ:

- 1.1.Тулгарч буй асуудал, түүний мөн чанар, цар хүрээ;
- 1.2.Тухайн асуудал үүссэн шалтгаан нөхцөл.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО:

- 2.1.Үндсэн зорилго, зорилт.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛАЛТ:

- 3.1.Асуудал зохицуулалтын хувилбаруудыг тогтоох.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨ:

- 4.1.Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

- 4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө;
- 4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө;
- 4.1.3. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө.

- 4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж буй эсэх талаар

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТУУДЫН ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛАЛТ, ДҮГНЭЛТ:

ЗУРГАА. ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ БУСАД ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН, ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА:

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ:

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН:

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал /цаашид Аргачлал гэх/-ын 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ:

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хууль нь Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих, ард иргэдийн амьжиргааг сайжруулахад чухал нөлөөтэй юм.

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлон улмаар түүнийг үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1 Тулгарч байгаа асуудал, түүний мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, холбогдох төрийн захиргааны төв болон төрийн байгууллагууд, бүх төрлийн шатахуун импортлогч, борлуулагч аж ахуйн нэгжүүд, мэргэжлийн холбоодоос нөхцөл байдлын талаарх судалгаа, лавлагаа, тоон мэдээллийг цуглуулж, эрх зүйн акт, тус асуудлаар өмнө хийсэн судалгаа, тодорхой тохиолдлыг судлах, нэгтгэх хэлбэрээр чанарын мэдээлэл цуглуулсан болно.

Эрх зүйн зохицуулалт:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Засгийн газар нь “Эдийн засгийн харилцааг аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийн сонирхолд нийцүүлэн зохицуулж, шударга өрсөлдөөнийг дэмжин дангаар ноёрхлыг хязгаарлах, эдийн засгийн тэнцвэрийг сайжруулах арга хэмжээ авна” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ” гэж;

2. Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6-д “Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулахыг хориглоно” гэж;

3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33.1.1-д “салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж;

4. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.3.1.9-д "Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна" гэж;

5. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 126 дугаар тогтоолд "Бүх төрлийн шатахуун импортлох, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн 2026 онд бүрдүүлэх газрын тосны бүтээгдэхүүний 30 хоногийн компанийн нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг Аи-92 автобензин 64,500 тонн, Аи-95/98 автобензин 1,280 тонн, дизель түлш 120,500 тонн, агаарын хөлгийн /ТС-1/ түлш 6,200 тонн, шингэрүүлсэн шатдаг хий 3,400 тонн, нийт 195,880 тонн-байна гэж;

6. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 98 дугаар тогтоолоор баталсан "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийн 4.3.2-т "Евро-5 стандартад нийцсэн, чанарын шаардлага хангасан шатахууны импорт, хэрэглээг дэмжих, стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг импортоор оруулах, хэрэглэхийг үе шаттайгаар хориглох, шатахууны чанарын хяналтын тогтолцоог сайжруулах гэж, мөн "Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийн 5.2-ийн 118-д "Евро-5" стандартад нийцсэн шатахууны эзлэх хувийг 2025 онд 80 хувьд хүргэнэ" гэж;

7. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 4.2-т "Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно" гэж тус тус заасан.

Практик хэрэгжилтийн байдал:

Өнөөдрийн байдлаар манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд нийт импортын 95 орчим хувийг ОХУ, үлдсэн хувийг БНХАУ эзэлж байна.

Улс орны нийгэм, эдийн засаг, уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлттэй холбоотойгоор манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа бөгөөд 2023 онд 2.4 сая тонн, 2024 онд 2.8 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн тус тус импортлон хэрэглэж, өмнөх оны мөн үеэс даруй 21,0 хувиар өссөн бол 2025 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн байдлаар импортын хэмжээ 2.3 сая тоннд хүрээд байна.

Манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын Засгийн газар болон нийлүүлэгч компаниудаас тус улсын дотоодын зах зээлийн нөхцөл байдал, эрэлт, нийлүүлэлттэй холбоотойгоор гаргасан экспортын хязгаарлалт, үйлдвэрлэлийн процесс, ээлжит засвар, төлөвлөгөөт ажлаас шалтгаалсан нийлүүлэлтийн хэмжээний бууруулалт зэрэг арга хэмжээнүүд нь манай улсын шатахууны хангамжийн тогтвортой байдалд шууд нөлөөлж, тасалдал хомсдол үүсгэн, эрэлтийг нэмэгдүүлж, үнийн хэлбэлзлийг бий болгосоор ирсэн. Тухайлбал 2021 оны 10 дугаар сард ОХУ-ын "Роснефть" компани АИ-92

автобензиний шатахууны сарын нийлүүлэлтийн хэмжээг бууруулсантай холбоотойгоор манай улсын дотоодын зах зээлд дээр АИ-92 шатахууны хангамж доголдож, тасалдал хомстол үүссэн, мөн ОХУ-ын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 1537 дугаар тогтоолоор шатахууны экспортыг түр хугацаанд хориглосны улмаас Монгол Улс руу ачигдах газрын тосны бүтээгдэхүүний тээвэрлэлт зогсож, нийт 21 хоногийн хугацаанд импорт хийгдээгүйгээс шалтгаалан дотоодын зах зээл дээр түлш, шатахууны хангамж доголдож, тасалдал хомстол үүсэх эрсдэлүүд тулгарч байсан болно.

Манай улсын ард иргэдийн өргөн хэрэглээний АИ-92 автобензиний хэрэглээ 2024 онд сард дунджаар 60,0 мянган тонн байсан бол 2025 онд сард дунджаар 80 мянган тоннд хүрч өсөөд байгаа боловч ОХУ-ын "Роснефть" компанитай хийсэн гэрээний хүрээнд хөнгөлөлттэй үнээр буюу 705,0 ам.долларын тогтмол үнээр нийлүүлж буй энгийн АИ-92 автобензиний сард нийлүүлэх хэмжээ тодорхой шалтгааны улмаас 60,0 мянган тонноор хязгаарлагдаж, нэмэгдүүлэх боломжгүй нөхцөл байдалтай байна. Иймд үлдсэн 20,0 мянга орчим тонны хэрэглээг бусад эх үүсвэр буюу БНХАУ-аас олон улсын зах зээлийн үнээр худалдан авч хангахаас аргагүй нөхцөл байдалд хүрээд байна.

Иймээс шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангахтай холбогдуулан улсын хэмжээнд 30-аас доошгүй хоногийн тогтмол нөөцтэй байх зорилтын хүрээнд импортлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, нөөцийг бүрдүүлэх, хадгалах савны хүчин чадал, багтаамжийг нэмэгдүүлэх, бодит (практик) шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:

Өнөөдрийн байдлаар манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд нийт импортын 95 орчим хувийг ОХУ, үлдсэн хувийг БНХАУ эзэлж байна.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг:

1. Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдал нь улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих, ард иргэдийн амьжиргааг сайжруулах, уул уурхай, зам тээвэр, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэл зэрэг бүхий л салбарын хэвийн үйл ажиллагаанд чухал нөлөөтэй байдаг тул энэхүү хуулийн хэрэгжилт нь нийт ард иргэд, бүх салбарт хамааралтай.

2. Шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангахад шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний нэг сар (30 хоног)-аас доошгүй хэрэглээний нөөцийг хадгалах, агуулах барихад шаардагдах хөнгөлөлттэй санхүүжилтийг олгох зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

1.2 Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан:

Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг алдагдуулж буй шалтгаан, нөхцөл нь гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс хамааралтай, нийлмэл шинжтэй байна.

1. Гадаад хүчин зүйл:

- ОХУ-ын "Роснефть" компанийн нийлүүлэлтийн хязгаарлалт (2021.9 сард);

- ОХУ-ын Засгийн газрын 2023 оны 1537 дугаар тогтоолоор экспортыг хязгаарласан;
- АНУ-ын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “импортын зохицуулалтын” захирамжийн улмаас дэлхийн нийлүүлэлтийн сүлжээ, шатахуун, түүхий эдийн үнийн өсөлт;
- Геополитикийн зөрчил, тээвэр-логистикийн тасалдлын манай улсын импортын систем дэх шууд нөлөөлөл.

2. Дотоод хүчин зүйл:

- Импортын эх үүсвэрийн төвлөрөл (95% ОХУ-д хамаарах);
- Нөөцийн бодлого, дэд бүтцийн хүчин чадлын дутмаг байдал (агуулах, шилжүүлэн ачих байгууламж, буферийн нөөц хангалтгүй);
- Санхүүжилтийн өртөг өндөр, эргэлтийн хөрөнгө хүрэлцээгүй, валютын ханшийн мэдрэмж их;
- Хяналтын нэгдсэн тогтолцоо, төр, хувийн хэвшлийн мэдээллийн урсгал, ажлын уялдаа сул, шийдвэр гаргалт удаашралтай

3. Үр дагаврын түвшин:

Эдгээр хүчин зүйлсийн нөлөөгөөр богино хугацаандаа газрын тосны бүтээгдэхүүний нөөц багасаж хангамж доголдох, тасалдал хомсдол үүсэх, дунд хугацаандаа агуулах, дэд бүтэц-логистикийн хүчин чадал хүрэлцэхгүй болох, урт хугацаандаа дотооды боловсруулалт (хангамжийн төлөвлөлт, зохион байгуулалт)-ын чадавх сул хэвээр байх төлөвтэй байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ:

2.1 Ерөнхий зорилго: Газрын тосны бүтээгдэхүүний импортын хамаарал, хангамжийн тасалдал, үнийн савлагаа, дотоод нөөцлөлт болон дэд бүтцийн сул чадавх зэрэг нийлмэл шалтгаантай эрсдэлийг бууруулах замаар Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангах нь энэхүү асуудлыг шийдвэрлэх үндсэн зорилго болно. Энэхүү зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэгт тус тус заасан төрийн эдийн засгийн зохицуулалтын бүрэн эрх, эдийн засгийн аюулгүй байдлыг хамгаалах үүргийн хэрэгжилттэй нийцнэ.

2.2. Тусгай зорилтууд:

- Импортын хамаарлыг бууруулах, эх үүсвэрийг төрөлжүүлэх:
 - Нэг эх үүсвэрт буюу ОХУ-д төвлөрсөн нийлүүлэлтийн хамаарлыг багасгаж, БНХАУ болон бусад эх үүсвэрээс нийлүүлэлтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх;
 - Дотоод боловсруулах үйлдвэрийн төслүүдийг (жишээлбэл, газрын тос боловсруулах үйлдвэр) үе шаттайгаар ашиглалтад оруулах замаар дотоод үйлдвэрлэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх;
 - Импортын гэрээний нөхцөлийг тогтворжуулах, урт хугацааны гэрээ, эрэлт-нийлүүлэлтийн таамаглалд суурилсан төлөвлөлтийн эрх зүйн орчныг бүрдүүлэх.
- Нөөц бүрдүүлэлт ба хангамжийн тогтвортой байдлыг хангах:

- Улсын хэмжээнд 45 хоногийн шатахууны тогтмол нөөцтэй байх бодлогыг хэрэгжүүлэх;
 - Импортлогч аж ахуйн нэгжүүдэд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, агуулах, хадгалах савны хэмжээ, хүчин чадлыг нэмэгдүүлэх;
 - Буфер нөөцийн систем бий болгож, хангамжийн гэнэтийн тасалдлыг нөхөх механизм бүрдүүлэх;
 - Нөөц бүрдүүлэх бодлогыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Эдийн засгийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөртэй уялдуулах.
3. Санхүүжилтийн уян хатан тогтолцоо бүрдүүлэх:
- Импортлогч, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд репо арилжаа, төрийн баталгаа, үнэт цаасны санхүүжилтийн хөтөлбөр ашиглан санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар эргэлтийн хөрөнгийн өртгийг бууруулах;
 - Монголбанк болон арилжааны банкуудын хамтарсан төвлөрсөн санхүүжилтийн шугам нээж, шатахууны нөөц бүрдүүлэлтэд зориулсан тусгай зээлийн нөхцөл бүрдүүлэх;
 - Санхүүгийн урамшуулал, татварын хөнгөлөлт, хөрөнгө оруулалтын баталгааг хуульчилсан байдлаар дэмжих.
4. Мэдээлэл, хяналтын нэгдсэн системийг хөгжүүлэх
- Импорт, агуулах, түгээгүүрийн сүлжээний бодит цагийн мэдээллийг нэгтгэсэн дижитал хяналтын платформ бий болгох;
 - Шатахууны үнэ, нөөц, хэрэглээ, татан авалтын мэдээллийг нээлттэй тайлагнах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
 - Хяналт-шинжилгээ, үнэлгээний системийг олон улсын туршлагад нийцүүлж, төр–хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилсан шилэн тайлагналын тогтолцоо бүрдүүлэх.
5. Эрсдэлийн урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөлт
- Нийлүүлэлтийн тасалдал, үнийн огцом хэлбэлзэл, байгалийн болон зохицуулалтын эрсдэлийн хувилбарын төлөвлөгөө боловсруулах;
 - Богино, дунд, урт хугацаанд хэрэгжих хариу арга хэмжээний төлөвлөгөө, хариуцлагын уялдаа бүхий байгууллагын бүтцийг тодорхойлох;
 - Төрийн байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцоог түргэн шуурхай болгох, эрсдэлийн дохиоллын систем нэвтрүүлэх.
6. Салбарын эрх зүйн орчин, бодлогын сайжруулалт:
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, агуулах, түгээх станцын холбогдох төлөвлөлтийн үеийн болон угсралт, ашиглалт, аюулгүй ажиллагаа зэрэг техникийн баримт бичгийг олон улсын жишиг, баримт бичигт тулгуурлан боловсронгуй болгох;
 - Хууль тогтоомжийн давхардал, хийдлийг арилгах, хэрэгжилтийг хангах хяналтын тогтолцоог сайжруулах;

2.3. Хүлээгдэж буй үр дүн:

- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль болон холбогдох эрх зүйн баримт бичгийг шинэчлэх, сайжруулах, шатахуун хадгалах, агуулах, түгээх станцын төлөвлөлт, угсралт, ашиглалт, аюулгүй ажиллагааны стандарт, техникийн

баримт бичгийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн норм, стандартад нийцүүлэн боловсронгуй болгох;

- Шатахууны импортын хамаарлыг бууруулж, 2028 он гэхэд 70 хувиас доош болгох;
- Улсын хэмжээнд 45 хоногийн тогтмол шатахууны нөөц бүрдэж, богино хугацааны тасалдал, хомсдолд өртөх эрсдлийг 50 хүртэл хувиар буурах;
- Импортлогч, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтийн өртөг 15–20 хувиар буурч, шатахууны ханган нийлүүлэлтийн санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөөлөл үзүүлэх;
- Мэдээлэл, хяналтын нэгдсэн систем бүрдэж, шилэн тайлагналт, хяналт-шинжилгээний үр дүн дээшлэх, шатахууны импорт, агуулах, түгээх станцын мэдээллий нэгдсэн систем бүрдэж, зах зээлийн мэдээлэл ил тод, бодит болох;
- Шатахууны үнийн хэлбэлзэл, ханшийн савлагаанд хариу үзүүлэх чадавх нэмэгдэж, эдийн засгийн аюулгүй байдал, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт бодитоор хангагдах;

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛАЛТ

3.1. Ерөнхий зорилго: Газрын тосны бүтээгдэхүүн болон бусад стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, импортын хамаарлыг бууруулах, стратегийн нөөц бүрдүүлэх, дотоодын боловсруулалтын чадавхыг нэмэгдүүлэх, мөн мэдээлэл–хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн үндсийг бий болгох зорилготой. Эдгээр зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 5.4 дэх хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 8.4, 8.5 дахь хэсэгт заасан төрийн эдийн засгийн зохицуулалт, эдийн засгийн аюулгүй байдлыг хамгаалах бүрэн эрхтэй уялдаж байна.

3.2. Хувилбар 1. Одоогийн мөрдөж буй Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, түүнтэй холбоотой журам, стандартын хүрээнд бодлогын нэмэлт, өөрчлөлт оруулахгүй. Салбар хоорондын уялдаа, хяналт, нөөцлөлтийн тогтолцоо одоогийн түвшинд үргэлжилнэ.

Эерэг тал:

- Шинэ хууль, журам боловсруулах нэмэлт зардал шаардахгүй;
- Байгууллагын бүтэц, одоогийн зохион байгуулалт, зах зээлийн тогтолцоо өөрчлөгдөхгүй;
- Хууль, журмын хэрэгжилт тасалдалгүй үргэлжилнэ.

Сөрөг тал:

- Импортын 100 хувийн хамаарал хэвээр үлдэж, эдийн засгийн эрсдэл буурахгүй;
- Стратегийн нөөц бүрдүүлэх, дотоод боловсруулах бодлого орхигдож, хангамжийн тогтворгүй байдал үргэлжилнэ;

- Мэдээлэл, хяналтын нэгдсэн систем бүрдэхгүй, төр хувийн хэвшлийн уялдаа сул хэвээр байна;
- Хангамжийн тасалдал, үнийн савлагаа, ханшийн мэдрэмжийн сөрөг нөлөө үргэлжилнэ.

3.3. Хувилбар 2. Засгийн газрын тогтоол, журам, шийдвэрийн хүрээнд шатахууны импорт, нөөц, үнийн хяналт, санхүүжилтийн дэмжлэгийг түр хугацаанд (жишээлбэл, 2027 он хүртэл) захиргааны аргаар зохицуулах. Энэхүү хувилбар нь онцгой нөхцөлд богино хугацаанд хангамжийн тогтвортой байдлыг хамгаалах зорилготой.

Эерэг тал:

- Богино хугацаанд хангамжийн тасалдалд хариу арга хэмжээ авах, импортын доголдлыг зохицуулах боломж бүрдэнэ;
- Импортлогч аж ахуйн нэгжүүдэд төрийн шуурхай дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдэнэ;
- Онцгой нөхцөлд нөөцөөс хангах, татан авалтыг зохицуулах уян хатан механизм бий болно.

Сөрөг тал:

- Эрх зүйн тогтвортой бус, хугацааны хувьд түр зохицуулалт тул хууль ёсны баталгаа сул.
- Санхүүжилтийн ил тод байдал сулрах, хяналт хангалтгүй байх эрсдэлтэй.
- Урт хугацааны бүтэц, бодлого бүрдэхгүй, импортын хамаарал хэвээр үлдэнэ.
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, дотоод боловсруулах санаачилга буурах хандлагатай.

3.4. Хувилбар 3 “Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хууль”-ийг батлан хэрэгжүүлэх (Санал болгож буй хувилбар) Шинэ хууль батлан хэрэгжүүлснээр стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүнүүд болох газрын тосны бүтээгдэхүүн (Аи-92 шатахуун, дизель түлш, агаарын хөлгийн түлш, авиа түлш, LPG)-ий хангамж, нөөц бүрдүүлэлт, санхүүжилт, мэдээлэл, хяналтын тогтолцоог бүрдүүлэх асуудлыг зохицуулна.

3.5. Харьцуулсан дүн шинжилгээ:

Үзүүлэлт	Хувилбар 1: Одоогийн зохицуулалт	Хувилбар 2: Түр хугацааны зохицуулалт	Хувилбар 3: Шинэ хууль батлах
Хэрэгжилтийн хугацаа	Тогтмол, хуучин бүтэц	Түр хугацааны (2027 он хүртэл)	Урт хугацааны, тогтвортой
Эрх зүйн баталгаажилт	Сул	Дунд түвшин	Өндөр
Санхүүжилтийн шийдэл	Байхгүй	Түр дэмжлэг	Тогтвортой, системтэй
Хангамжийн тогтвортой байдал	Эмзэг	Түр тогтворжино	Тогтвортой, системийн

Нөөцийн чадавх	Хязгаарлагдмал	Хэсэгчлэн бүрдэнэ	30–45 хоногийн нөөцтэй
Эдийн засгийн үр нөлөө	Хязгаарлагдмал	Түр хугацаанд	Цогц, урт хугацааны
Мэдээллийн ил тод байдал	Байхгүй	Хэсэгчлэн	Нэгдсэн систем бүрдэнэ

3.6. Дүгнэлт:

Хууль зүйн болон эдийн засгийн талаас авч үзэхэд:

- Хувилбар 1 нь бодит өөрчлөлт үзүүлэхгүй, эрсдэлийн түвшинг бууруулах боломжгүй;
- Хувилбар 2 нь богино хугацаанд үр дүн өгч болох хэдий ч эрх зүйн тогтвортой байдлыг хангахгүй;
- Хувилбар 3 буюу “Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хууль”-ийг батлан хэрэгжүүлэх нь урт хугацааны, тогтвортой, системийн шийдэл бөгөөд импортын хамаарлыг бууруулж, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах хамгийн оновчтой хувилбар гэж үзнэ.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ:

1. Хүний эрхэд үзүүлэх нөлөө:

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1 Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1 Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хууль нь иргэдийн гарал үүсэл, хүйс, нийгмийн байдал, орлого зэргээс үл хамааран тэгш хүртээмжийг хангана.
	1.1.2 Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Зохицуулалт нь зах зээлийн бүх оролцогчдод адил үйлчилнэ, онцгой давуу байдал бий болгохгүй.
	1.1.3 Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Олон улсын хүний эрхийн конвенц, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлтэй нийцэж, эмзэг бүлгийн хүртээмжийг дэмжинэ.
	1.2 Оролцоог хангах	<u>Тийм</u>	Үгүй	Оролцогч талууд, тэр дундаа хэрэглэгч, хувийн хэвшлийн

				оролцоог зөвлөлдөх, ил тод байдлаар хангах.
	1.2.1 Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Нийт иргэдийн хүртээмжийг сайжруулах, хангамжийн тогтвортой байдлаар тэгш оролцоог хангана.
	1.2.2 Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хууль хэрэгжилтийн хүрээнд хэрэглэгч, жижиг ААН-ийн эрх ашгийг тусгасан.
	1.3 Хууль дээдлэх зарчим басайн засаглал, хариуцлага	<u>Тийм</u>	Үгүй	Хариуцлагын тогтолцоо тодорхой, хууль дээдлэх зарчимд тулгуурласан.
	1.3.1 Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хангамж, үнийн тогтвортой байдал нь амьдрах эрхийг хамгаална.
	1.3.2 Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь IEA/EU жишигт нийцсэн.
	1.3.3 Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хуулиар торгууль, эрх хязгаарлалт, хариуцлагын протокол тусгагдана.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1 Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалахад чиглэнэ.
	2.2 Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Онцгой нөхцөлд түр хугацаанд хэрэгжүүлэх протоколтой.
3. Эрх агуулагч	3.1 Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудын үүрэг тодорхой.

	3.2 Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Алслагдсан бүс, эмзэг бүлэг, жижиг ААН-ийг тусгайлан харгалзсан.
	3.3 Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүртээмж, үнийн дэмжлэг, нийгмийн хамгааллын буфертэй.
	3.4 Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	<u>Тийм</u>	Үгүй	Тээвэр, шатахуун хүртээмжийн бүсчилсэн зохицуулалт бий.
4. Үүрэг хүлээгч /9/	4.1 Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Засгийн газар, Монголбанк, салбарын яам, орон нутгийн захиргаа, ААН-ийн үүрэг тодорхой.
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1 Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хөдөлмөрийн тэгш оролцоо, ХАБЭА стандарт мөрдөнө.
	5.2 Эрэгтэй эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Төрийн болон хувийн хэвшлийн түвшинд жендерийн тэгш байдлыг хангана.

2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө:

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1 Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Нөөцлөлт, санхүүжилтийн өртөг буурснаар нийлүүлэлтийн эрсдэл багасаж, бүх тоглогчдын зардал тогтворжино; шударга өрсөлдөөнд эерэг.
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар	1.2 Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх	<u>Тийм</u>	Үгүй	Ил тод эрх зүй, тогтвортой хангамж нь дэд бүтэц, агуулах, логистикт

болон тогтвортой байдал	эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оруулан)			гадаад хөрөнгө татах суурь болно.
	1.3 Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Буфер нөөц, олон эх үүсвэртэй импорт, урт гэрээ нь гаднын савлагааг зөөллөнө.
	2.1 Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Хангамж тогтвортой бол бараа тасалдахгүй, сонголт нэмэгдэнэ.
	2.2 Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Мэдээллийн ил тод систем, олон эх үүсвэр нь үнийн хөөрөгдлийн орон зайг хумина.
	2.3 Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Журмын тодорхой байдал, санхүүгийн хөшүүрэг нь шинэ оролцогчдод боломж нээнэ.
	2.4 Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ил тод тайлагнал, хяналт, өрсөлдөөний бодлоготой уялдуулж хэрэгжинэ.
3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл ийн болон захиргааны зардал	3.1 Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Нөөцлөлт, тайлагналын зардал бий. Гэхдээ санхүүжилтийн өртөг бууралт, эрсдэлийн багасалтаар цэвэр үр ашиг зэрэг.
	3.2 Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Репо, баталгаат санхүүжилт, үнэт цаасны хөтөлбөрөөр өртөг буурна.
	3.3 Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Төрөөс тодорхой барааг шахахгүй; чанар, стандартын шаардлага л тавина.
	3.4 Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Онцгой нөхцөлд түр зохицуулалт байж болох ч ердийн үед хязгаарлахгүй.

	3.5 Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Эсрэгээрээ тасалдлын эрсдэл буурна.
4. Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1 Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Нэгдсэн платформд мэдээлэх зардал гарна. Автоматжуулснаар тогтмол бага зардал болж тогтворжино.
5. Өмчлөх эрх	5.1 Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Өмч хураахгүй; зөвхөн стандарт, аюулгүй ажиллагааны шаардлага тавина.
	5.2 Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Зах зээлийн эрх чөлөөг хадгална; зөвшөөрлийн шалгуур тодорхой болно.
	5.3 Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Стандарт, мэдээллийн систем нь оюуны өмчийг хөндөхгүй.
6. Инновац болон судалгаа шинжилгээ	6.1 Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Агуулах, түгээх станцын хяналтын дижитал систем, чанарын мониторинг зэрэг технологийн эрэлт бий болно.
	6.2 Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох	<u>Тийм</u>	Үгүй	Санхүүжилтийн хөшүүрэг, стандартчилал нь шинэ тоног төхөөрөмж, IT систем нэвтрэх суурь.
7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1 Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Богино хугацаанд тогтворжилт; урт хугацаанд савлагаа буурна.
	7.2 Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Тасалдал багасаж, хүртээмж нэмэгдэнэ.
	7.3 Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Ил тод мэдээлэл, тогтвортой хангамж нь хэрэглэгчийг хамгаална.

	7.4 Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Савлагаа багассанаар зардлын таамаглал сайжирна
8. Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1 Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох	<u>Тийм</u>	Үгүй	Агуулах, логистик, ИТ, аюулгүй ажиллагааны чиглэлд нэмэлт ажил байр.
	8.2 Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Зогсолт багассанаар ажлын байрны эрсдэл буурна.
	8.3 Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Түлшний тогтвортой байдал нь ЖДҮ-ийн тасралтгүй ажиллагаанд эерэг.
9. Төрийн захиргааны байгууллага	9.1 Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Эхний үе шатанд хөрөнгө, системийн зардал; дунд хугацаанд үр ашиг, татварын орлогоор нөхөгдөнө.
	9.2 Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	<u>Тийм</u>	<u>Үгүй</u>	Шинэ байгууллага зайлшгүй биш; харин “нэгдсэн хяналтын нэгж/тохируулга” шаардагдаж магадгүй.
	9.3 төрийн байгууллагад захиргааны чиг үүрэг бий болгох эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Мэдээлэл, мониторинг, нөөцийн бодлогын уялдаа нэмэгдэнэ.
10. Макро эдийн засгийн хүрээнд	10.1 Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Тасалдлын эрсдэл буурч, үйлдвэрлэлийн тасралтгүй байдал дэмжигдэнэ.
	10.2 Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Тогтвортой орчин нь урт хугацааны хөрөнгө оруулалтыг татна.
	10.3 Инфляц нэмэгдэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Нөөц, олон эх үүсвэр нь нийлүүлэлтийн шокийг зөөлрүүлж, инфляцын дарамтыг бууруулна.

11. Олон улсын харилцаа	11.1 Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	<u>Тийм</u>	Үгүй	WTO, IEA/EU чиг хандлагатай нийцсэн, зах зээлийн зарчимтай.
-------------------------	--	-------------	------	---

3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө:

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1 Шинээр ажлын байр бий болох эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Агуулах, логистик, лаборатори, IT хяналт, аюулгүй ажиллагаанд эрэлт нэмэгдэнэ.
	1.2 Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Тасалдал буурч, үйлдвэрлэл тогтвортой явагдана.
	1.3 Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Тээвэрлэлт, засвар үйлчилгээ, жижиглэнгийн сүлжээний орлого тогтворжино.
	1.4 Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Залуучууд, ахмадын хөдөлмөр эрхлэлтэд шууд ба шууд бусаар дэмжлэгтэй.
2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1 Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Олон улсын стандарт нэвтрүүлснээр чанар дээшилнэ.
	2.2 Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Агуулах, түгээх станцын шатахуунтай харьцах аюулгүй ажиллагаа сайжирна.
	2.3 Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Стандарт, сургалт, хамгаалах хэрэгсэл тогтмолжино.
	2.4 Шинээр ажлын стандарт гаргах эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Төлөвлөлт, угсралт, ашиглалт, ослын менежментэд шинэчилсэн баримт бичиг гарна.
	2.5 Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Мэдээллийн платформ, хэмжилтийн төхөөрөмж, алсын хяналт.
3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1 Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		<u>Үгүй</u>	Үйлчлэл нь бүх бүс нутаг, бүлгүүдэд ижил.
	3.2 Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг,	Тийм	<u>Үгүй</u>	Нааштай: алслагдсан бүсийн хүртээмж сайжирна.

	хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт			
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1 Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хамтын ажиллагаа гүнзгийрнэ.
	4.2 Төрийн байгууллагын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Нэгдсэн хяналт, тайлагнал, уялдаа нэмэгдэнэ.
	4.3 Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хариуцлагын матриц тодорхой болно.
	4.4 Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Ил тод байдал, маргаан шийдвэрлэх суваг тодорхой болно.
	4.5 Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Бодлогын хэлэлцүүлэгт тоон мэдээлэл, ил тод байдал нэмэгдэнэ.
5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1 Хувь хүн, нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Эрүүл мэндийн үйлчилгээ, тээвэр тасалдах эрсдэл буурна.
	5.2 Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Стандарт, алдагдлыг бууруулах технологиор сөрөг нөлөөг хязгаарлана.
	5.3 Хүмүүсийн амьдралын хэв маяг(хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Шууд нөлөө бага; тээврийн хүртээмж сайжирна.
6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1 Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Түлшний доголдолгүй бол нийтийн үйлчилгээ тасалдахгүй.
	6.2 Ажилчдын боловсрол шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Шинэ стандарт, сургалтын эрэлт бий.
	6.3 Иргэдийн боловсрол (Төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Эсрэгээрээ тээврийн тасалдал буурна.
	6.4 Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Тээвэр, дулаан, цахилгаан тогтвортой.

	6.5 Их дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Судалгаа, сургалт, стандартын хамтын ажиллагаа нэмэгдэнэ.
7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1 Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Түлшний хомсдолын үеийн сөрөг нөлөө (эмх замбараагүй байдал) эрсдэл буурна.
	7.2 Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Зөрчил, хууль сахих байдал тодорхой болно.
	7.3 Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Мэдээллийн мөрдөлт, логикийн мөртэй байдал сайжирна.
	7.4 Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Шууд хамаарал бага, гэхдээ ил тод байдал нь нийтлэг эрхийг дэмжинэ.
8. Соёл	8.1 Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Дэд бүтцийн зөв байршил, хамгаалалтын дэглэм мөрдвөл сөрөг нөлөөгүй.
	8.2 Хэл соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөлгүй.
	8.3 Иргэдийн түүх соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Ил тод байдал, олон нийтийн оролцоо нэмэгдэнэ.

4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Агаар	1.1 Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Алдагдал ууршилтыг бууруулах стандарт, чанарын хяналтаар сөрөг нөлөөг хязгаарлана.
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1 Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх /бууруулах эсэх/	<u>Тийм</u>	Үгүй	Хангамж тогтворжилт хэрэглээг буруу өдөөхгүй, логистик оновчлохоор нийт хэрэглээний үр ашиг сайжирна.
	2.2 Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Агуулах, түгээх байгууламжуудад шатахуун буулгах, ачих үед цахилгаан ашиглана, гэхдээ үр

				ашгийг өсөлтөөр нөхнө.
	2.3 Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Түлшний тогтвортой байдал нь дизель-генераторын найдвартай ажиллагааг дэмжинэ.
	2.4 Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Чанарын стандарт, хяналт, LPG/цэвэр түлшийг дэмжих бодлогоор саармагжина.
3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1 Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Төслийн байршлын онцлог, барилгын зураг төсөл, олон улсын чанар, аюулгүй байдлын стандартад нийцсэн мэргэжлийн зураг төслийн ажлыг боловсруулна
	3.2 Ховордсон болон нэн ховордсон амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	БО-ын үнэлгээ, хамгаалалтын дэглэм мөрдөнө.
	3.3 Ан амьтан нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Маршрут/байршлын үнэлгээний дагуу зайлсхийх.
	3.4 Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	ТХГН-д дэд бүтэц төлөвлөхгүй.
4. Усны нөөц	4.1 Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Сав, шугам хоолойн битүүмжлэл, алдагдлын мониторинг.
	4.2 Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Асгарлын тусгай төлөвлөгөө, байгальд алдагдлыг 0-т ойртуулах зорилт.
	4.3 Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Ус хамгаалалтын бүсчлэл, ослын бэлэн байдлын протокол мөрдөнө.
5. Хөрсний бохирдол	5.1 Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Давхар ханатай сав, хөрсөнд шатахуун алдагдах үед мэдрэгч ажиллах автомат тонголол.
	5.2 Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	

6. Газрын ашиглалт	6.1 Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах	<u>Тийм</u>	Үгүй	Аж үйлдвэрийн бүсэд төвлөрүүлнэ.
	6.2 Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	
	6.3 Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Хориотой.
7. Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1 Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Алдагдлыг бууруулж, үр ашиг өсгөнө.
	7.2 Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хангамж тогтвортой болох нь хэрэглээг зохистой болгоно; бодлогоор үр ашгийг нэмэгдүүлнэ.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ:

Газрын тосны бүтээгдэхүүн болон бусад стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдал, импортын хамаарал, дотоод нөөцлөлт, санхүүжилт, мэдээлэл-хяналтын тогтолцоо зэрэг нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдлын гол хүчин зүйл болж байна. Энэхүү нөхцөл байдлыг харгалзан асуудлыг шийдвэрлэх гурван хувилбарыг хууль зүйн, эдийн засгийн, институтын болон хэрэгжилтийн түвшинд харьцуулан судлахад дараах дүгнэлт гарч байна.

Хувилбар 1. Одоогийн хууль, зохицуулалтыг хэвээр хадгалах: Энэхүү хувилбар нь шинэ эрх зүйн орчин бүрдүүлэхгүйгээр, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн одоогийн хэрэгжилт, холбогдох журам, стандартын хүрээнд үргэлжлүүлэхийг илэрхийлнэ. Хэдийгээр зардал, бүтэц өөрчлөгдөхгүй тогтвортой байдлыг түр хадгалж болох ч, бодит байдалд импортын 100 хувийн хамаарал, хангамжийн тасалдал, үнийн савлагаа, ханшийн эрсдэл үргэлжилж, эдийн засгийн аюулгүй байдал улам эмзэг хэвээр байна.

Дүгнэлт: Энэхүү хувилбар нь “хууль зүйн тогтвортой байдал” гэсэн гадна талын хэвийн байдлыг хадгалж болох ч эдийн засгийн бодит эрсдэлийг бууруулах чадамжгүй, стратегийн бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдалд бодит шийдэл авчрахгүй. Иймд энэхүү хувилбар төрийн бодлогын зорилтод нийцэхгүй гэж үзнэ.

Хувилбар 2. Түр хугацааны захиргааны зохицуулалт хэрэгжүүлэх: Энэ хувилбар нь Засгийн газрын тогтоол, журам, шийдвэрийн түвшинд шатахууны импорт, нөөц, үнэ, санхүүжилтийн асуудлыг түр хугацаанд зохицуулах хэлбэр юм. Онцгой нөхцөлд хангамжийн доголдлыг түр хугацаанд нөхөх, богино хугацаанд зах зээлийг тогтворжуулах шуурхай арга хэмжээ авах боломжтой ч, эрх зүйн баталгаа сул, хяналт-шинжилгээний механизм бүрэн бус тул урт хугацаанд тогтвортой шийдэл болж чадахгүй.

Дүгнэлт: Энэ хувилбар нь “онцгой нөхцөлд хариу арга хэмжээ авах” богино хугацааны бодлогын хэрэгсэл байж болох ч, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах байнгын хууль зүйн үндэс болох боломжгүй. Хугацааны хувьд 2027 он хүртэл хэрэгжих түр журам байлаа ч, хууль ёсны тогтвортой байдал, хувийн хэвшлийн итгэлийг бүрдүүлэхэд хангалтгүй.

Хувилбар 3. “Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хууль”-ийг батлан хэрэгжүүлэх (Санал болгож буй хувилбар) Энэхүү хувилбар нь шинэ эрх зүйн орчин бүрдүүлж, шатахуун болон бусад стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нөөц, санхүүжилт, хяналтын тогтолцоог нэгдсэн хуульд суурилан зохицуулах зорилготой.

Хуулийн хүрээнд:

- Импортын хамаарлыг шат дараатай бууруулж, олон эх үүсвэр бүхий тогтвортой хангамжийн систем бүрдэнэ;
- Улсын хэмжээнд 45 хоногийн шатахууны нөөц бүрдэх боломжтой болно;
- Репо арилжаа, баталгаат санхүүжилт зэрэг уян хатан санхүүгийн хэрэгслүүд нэвтрэн, өртөг 15–20%-иар буурна;
- Мэдээлэл-хяналтын нэгдсэн систем бүрдэж, шийдвэр гаргалт ил тод, бодит цагийн горимд суурилна;
- Эдийн засгийн аюулгүй байдал, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт урт хугацаанд баталгаажна.

Дүгнэлт: Хувилбар 3 нь эдийн засгийн болон хууль зүйн үүднээс хамгийн оновчтой, тогтвортой шийдэл юм. Хэдийгээр хэрэгжилтэд тодорхой хэмжээний хөрөнгө, байгууллагын уялдаа, зохицуулалтын шинэчлэл шаардагдах ч, эдийн засгийн аюулгүй байдал, эрчим хүчний хараат бус байдлыг хангах системийн өөрчлөлт авчрах чадвартай.

1. Харьцуулсан шинжилгээ, товч хүснэгт:

Үзүүлэлт	Хувилбар 1: Одоогийн байдал	Хувилбар 2: Түр зохицуулалт	Хувилбар 3: Шинэ хууль
Эрх зүйн тогтвортой байдал	Өндөр (хуучин хуульд тулгуурласан)	Түр, тогтворгүй	Байнгын, тогтвортой
Эдийн засгийн аюулгүй байдалд нөлөө	Сул	Хязгаарлагдмал	Өндөр
Импортын хамаарал буурах нөлөө	Байхгүй	Түр хугацаанд	Урт хугацаанд
Нөөц бүрдүүлэлтийн чадавх	Хязгаарлагдмал	Хэсэгчлэн	45 хоногийн нөөц
Санхүүжилтийн өртөг	Өндөр	Хэсэгчлэн буурна	15–20%-иар буурна
Мэдээллийн ил тод байдал	Сул	Хэсэгчлэн	Нэгдсэн систем
Хэрэгжилтийн хугацаа	Тогтмол, хуучин бүтэц	Түр (2027 он хүртэл)	Урт хугацааны

Хувийн хэвшлийн оролцоо	Сул	Хязгаарлагдмал	Тогтвортой, түншлэлийн
-------------------------	-----	----------------	------------------------

ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН СУДАЛГАА

а. Олон улсын нийтлэг жишиг, зарчим:

1. Олон улсын эрчим хүчний хөтөлбөр (IEA)-ийн зарчим IEA-ийн гишүүн орнууд хамгийн багадаа сүүлийн 90 хоногийн цэвэр импорттой тэнцэх нефтийн нөөц байнга хадгалах үүрэгтэй бөгөөд нийлүүлэлтийн ноцтой доголдлын үед хамтарсан арга хэмжээг (нөөц гаргах, эрэлтийг хязгаарлах, шатахууныг орлуулах гэх мэт) авч хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалттай;
2. Европын Холбоо (ЕХ) - ЕХ нь 2009/119/ЕС Зөвлөлийн директиваар гишүүн бүрд хамгийн бага түвшний түүхий тос/нефть бүтээгдэхүүний нөөцийг тогтоосон (тооцоолол, ил тод тайлагнал, байгууллагын зохион байгуулалт, хяналт шалгалтын шаардлага зэргийг нарийвчилсан).

б. Улс, бүс нутгийн жишээ (харьцуулсан тойм)

1. Хойд Америк: АНУ – Стратегийн нефтийн нөөц (SPR) 1975 оны Energy Policy and Conservation Act-аар байгуулагдсан SPR нь дэлхийн хамгийн том төрийн эзэмшлийн түүхий тосны онцгой нөөц;
2. Техас, Люизианад давсны агуйд хадгалж, нийлүүлэлтийн тасалдалд хариулах, IEA-ийн үүргийг биелүүлэх хууль эрх зүйн суурьтай.
3. Европын Холбоо ЕХ – Дотоодын хэрэгжилтийн загвар 2009/119/ЕС-ийн дагуу гишүүд минимум нөөц тогтоон, бүтэц-байгууллага, тайлагнал, хяналтын механизмыг заавал бүрдүүлдэг. Энэ нь гишүүн бүрийн үндэсний хуульд буулгасан нийтийн стандарт.
4. БНСУ – Газрын тос, газрын тосны орлуулалттай түлшний тухай хууль ба Эрчим хүчний тухай хууль хоёр үндсэн хуулиар нефтийн онцгой нөөц, хариу арга хэмжээний тогтолцоо бүрдүүлсэн (KNOC-ийн гүйцэтгэл, төр-хувийн нөөц хосолсон загвар).
5. БНХАУ – Стратегийн нөөцийн бодлого (ил тод бус ч өндөр түвшинд хэрэгжиж буй) БНХАУ 2016–2024 онд 850 сая–1 тэрбум баррелийн дээд-доод хэлбэлзэлтэй өргөн хэмжээний нөөц шингээж ирсэн тухай хиймэл дагуул, худалдааны мэдээлэлд тулгуурласан судалгаа бий; 2025 онд ч нөөц хуримтлал эрчимтэй үргэлжилж байна.
6. Өмнөд ба Зүүн Өмнөд Ази - Энэтхэг – Стратегийн нефтийн нөөц (ISPR) Холимог (төр-хувийн) загвараар 5.33 сая тн хүчин чадал бүхий SPR байгуулаад цааш тэлэх төсөв, хөрөнгө оруулалтын шийдвэрүүдийг 2025/26 онд баталсан. Улсын хэмжээний (SPR + ОМС) нөөц багтаамж 70+ хоногт хүрдэг талаар албан мэдээлэл, төсвийн шийдвэрүүд байдаг.

7. ASEAN-ийн зарим орон (журам, зорилтот түвшин харилцан адилгүй) Тайланд ~25 хоногийн нөөцийн шаардлагатай; Вьетнам 90 хоногийн нөөцлөлтийн зорилт дэвшүүлсэн; Сингапурт төрийн албан ёсны нефтийн нөөц байхгүй/шаардлагагүй загвар (зах зээлд түшиглэсэн боомтын экосистем).

с. Зүй тогтол ба Монголд хэрэглэх боломжтой уялдаа:

1. “90 хоног”-ын босго, институтийн уялдаа. IEA, ЕХ-ны жишиг нь хуульд тулгуурласан нөөцийн доод түвшин + тайлагнал + хариу арга хэмжээний протокол гэсэн гурвалсан загварыг баталгаажуулдаг. Монгол Улс бүрэн 90 хоногт хүрэхээс өмнө шаталсан зорилт (жишээ нь: 30 → 45 → 60 хоног) тогтоож, ил тод тайлагнал-хяналтын систем-ийг зэрэг хөгжүүлэх шаардлагатай;
2. Төр-хувийн хосолсон нөөцлөлтийн загвар: АНУ, Япон, БНСУ, Энэтхэг зэрэгт төрийн SPR + хувийн албан нөөцийг хослуулж, онцгой үед дайчлах эрх-журмыг хуульчилсан байдаг. Энэ нь санхүүгийн ачааллыг бүхий л тоглогч хооронд хуваарилах, зах зээлийн уян хатан байдлыг хадгалах давуу талтай;
3. Санхүүжилтийн тогтолцоо: ЕХ-ны ил тод тайлагнал-хяналтын шаардлага, Энэтхэгийн төсөв-SPR загвар зэрэг нь нөөцлөлтийг төсөв, үнэт цаас, концесс/PPP-тай уялдуулж болохыг харуулдаг. Монголд репо, баталгаат санхүүжилт, татварын дэмжлэг зэргийг хослуулах нь бодитоор боломжтой;
4. Мэдээллийн ил тод байдал ба бодит цагийн хяналт: ЕХ-ны директив нь нөөцийн тоо хэмжээ, бүтэц, эрсдэлийн үнэлгээ, мэдээлэл солилцоо-г стандартчилж өгсөн; Зүүн Азийн жишээнүүд (Япон, БНСУ) онцгой үеийн протокол-оо урьдчилан хуульчилж, богино хугацааны шийдвэрийн хурдыг нэмэгдүүлдэг;
5. Зах зээлд түшиглэсэн онцлог (Сингапурын кейс) Гол боомт бүхий арилжааны зангилаанд төрийн албан нөөц шаардахгүйгээр зах зээлийн өрсөлдөөн, эргэлтийн хурдаар хангамжийг тогтвортой байлгах бодлого хэрэгжүүлж болох ч энэ нь Монголын дотоодын зах зээл, газарзүйн нөхцөлтэй шууд нийцэхгүй (хуурай газар, урт логистик, хүйтэн улирал, ганц эх үүсвэрийн эрсдэл өндөр).

d. Монгол Улсад тохируулах арга зүйн санал (олон улсын жишигт тулгуурлан)

1. Этапчилсан нөөцийн норм: IEA/EU жишгээр хуульчилсан доод түвшин тогтоож, 30 → 45 → 60 хоногийн шатлалтайгаар гүйцэтгэлээ үе шаттай өсгөх.
2. Төр-хувийн хосолсон загвар: АНУ, Япон, БНСУ, Энэтхэгийн адил SPR + албан нөөц (компанийн)-ыг давхардуулж, онцгой үед дайчлах хуульчилсан протокол батлах.
3. Санхүүжилтийн олон суваг: Энэтхэгийн төсвийн дэмжлэгийн жишгээр төсвийн шугам + репо/баталгаа + үнэт цаас (bond/PPPs)-ын хослолыг тодорхой эрх зүйн хүрээнд нэвтрүүлэх.
4. Ил тод тайлагнал, хяналтын нэгдсэн платформ: ЕХ-ны тайлагнал-хяналтын логик, Япон/БНСУ-ын онцгой үеийн журмыг загварчилж, бодит цагийн мэдээлэл-эрсдэлийн дохиолол бүхий дижитал платформыг хуульд тусгай бүлгээр журамлах.

5. Эх үүсвэрийн төрөлжилт: Бүс нутгийн бодлого (Энэтхэг, Вьетнам, Тайланд)-ын адил олон эх үүсвэрийн гэрээ, логистикийн маршрутыг урьдчилан бэлдэх; Сингапураас ил тод, зах зээлд тулгуурласан өрсөлдөөний механизмыг (ил тод үнэлгээ, дуудлага худалдаа) хэсэгчлэн нэвтрүүлэх.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛАХ

7.1 Ерөнхий зөвлөмж (сонгох хувилбар) Санал болгож буй хувилбар: Санал болгож буй хувилбар: “Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хууль”-ийг батлан хэрэгжүүлэх (Хувилбар 3).

Шалтгаан ба үндэслэл: Монгол Улс шатахуун, түлш зэрэг стратегийн бүтээгдэхүүний хэрэгцээгээ 100 хувь гадаад зах зээлээс импортлон хангаснаар хангамжийн тогтвортой байдалд өндөр эрсдэл үүсэж байна. Хил, тээвэр, ханшийн хэлбэлзэл болон дэлхийн зах зээлийн үнийн савлагаа зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан тасалдал, үнийн огцом өсөлт гарах магадлал маш өндөр. Эдгээр эрсдэлийг бууруулахын тулд түр журам, эсвэл нэг удаагийн зохицуулалт хангалтгүй бөгөөд хуульчилсан, тогтвортой эрх зүйн орчин, санхүүгийн урамшууллын хөшүүрэг, мэдээллийн нэгдсэн системийг хослуулсан “багц шийдэл” зайлшгүй шаардлагатай байна.

Энэхүү “багц” шийдэл дараах гурван үндсэн тулгууртай байх шаардлагатай.

1. Хуульчилсан тогтвортой эрх зүйн орчин -төр, хувийн хэвшлийн үүрэг, хариуцлага, нөөцийн доод хэмжээ, мэдээлэл ба тайлагналын журам тодорхой байх;
 2. Санхүүжилтийн хөшүүрэг - нөөц бүрдүүлэх, хадгалах, хяналт тавихад зориулсан бага хүүтэй зээл, баталгаа, төрийн дэмжлэгийг бий болгох;
 3. Мэдээллийн нэгдсэн систем - импорт, агуулах, үнэ, нөөцийн хөдөлгөөнийг бодит цагийн горимоор хянаж, ил тод байдлыг хангах.
- ❖ Хувилбаруудын харьцуулалт:
- Хувилбар 1 (одоогийн байдлыг хадгалах): ямар нэг шинэ арга хэмжээ авахгүй тул өнөөгийн хамаарал, тасалдал, үнийн савлагаа, хомсдол зэрэг эрсдэл хэвээр үлдэнэ.
 - Хувилбар 2 (түр журам): богино хугацаанд (1–2 сар) тодорхой үр нөлөө үзүүлж болох ч урт хугацаанд тогтвортой шийдэл болж чадахгүй.
 - Хувилбар 3 (хуульчилсан багц шийдэл): эрсдэлийг урт хугацаанд бууруулж, хангамжийн тогтвортой байдал, үнийн тэнцвэр, зах зээлийн итгэлийг хангах хамгийн үр дүнтэй, тогтвортой хувилбар юм.

7.2 Хууль, бодлогын зохицуулалт:

1. Хуулийн хүрээ, зорилго: “Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хууль”-ийн хүрээнд стратегийн бүтээгдэхүүн болох АИ-92/95/98 бензин, дизель түлш (ДТ), нисэхийн түлш (ТС-1), шингэрүүлсэн хий (LPG), тослох материалын хангамж, нөөц бүрдүүлэлт, санхүүжилт, мэдээлэл, хяналт, эрсдэлийн удирдлагыг нэгдсэн эрх зүйн хүрээнд зохицуулна.
2. **Нөөцийн норм:** Нөөцийн норм нь “эрэлт, нийлүүлэлт тасалдсан тохиолдолд дотоодын зах зээл хэдэн хоногийн турш тогтвортой байж чадах вэ” гэдгийг

хэмждэг эдийн засгийн болон эрсдэлийн удирдлагын стандарт үзүүлэлт юм. Улсын болон аж ахуйн нэгжийн түвшинд шаталсан зорилт бүхий нөөц бүрдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж:

- 2026 он гэхэд -30 хоногийн нөөцийн түвшинд хүрэх;
- 2027 он гэхэд - 45 хоногийн нөөц бүрдүүлэх зорилт тавина.

Энэхүү нормыг бүтээгдэхүүн тус бүрийн онцлог, хадгалалтын горим, чанарын стандарттай уялдуулан тогтооно. Уг шаталсан зорилт нь дотоодын хэрэглээг богино хугацаанд тогтвортой хангах, дунд хугацаанд нийлүүлэлтийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, урт хугацаанд олон улсын (IEA, EX)-ны 60 хоногийн стратегийн нөөцийн стандарт руу ойртох үндсэн зорилготой.

3. **Мэдээллийн ил тод байдал ба дижитал хяналт:** Импорт, агуулах, түгээлт, үнэ, нөөцийн талаарх мэдээллийг нэгтгэсэн дижитал хяналтын нэгдсэн платформ бий болгож, бодит цагийн горимоор мэдээлэл цуглуулах, тайлагнах, дүн шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлнэ.

- Тус систем нь төр, хувийн хэвшлийн мэдээллийн урсгалыг нэгтгэж, нээлттэй тайлан, дүн шинжилгээ, ил тод хяналтын зарчмаар ажиллана;
- Үүний үр дүнд хангамжийн тасалдлын урьдчилсан дохиолол (нөөцийн хоног, ханшийн мэдрэмж, хангамжийн төвлөрөл) гарч, шийдвэр гаргалт бодит мэдээлэлд суурилна.

4. **Эрх, үүрэг, хариуцлага:** Хуульд зааснаар Засгийн газар, Монголбанк, холбогдох яам, агентлаг, орон нутгийн захиргаа болон аж ахуйн нэгжүүдийн хариуцлагын матриц боловсруулна.

- Эрх, үүрэг тодорхойгүй байдлыг арилгаж, давхардалгүй зохицуулалт бий болгоно;
- Зөрчил, хяналт, тайлагналын зөрүү гарсан тохиолдолд торгууль, эрх хязгаарлалт, түдгэлзүүлэлт зэрэг хариуцлагын арга хэмжээ авна;
- Онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэрэгжүүлэх түр зохицуулалтын протокол боловсруулж, шуурхай арга хэмжээ авах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ.

5. **Холбогдох эрх зүйн уялдаа:** Энэхүү хууль нь бусад салбарын холбогдох хууль тогтоомжуудтай дараах байдлаар уялдан хэрэгжинэ:

- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль - нөөцийн бүрдүүлэлт, стандарт, хяналт, тайлагналын зохицуулалтыг шинэчлэн нэгтгэх;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль -стратегийн нөөцтэй холбоотой онцгой нөхцөлд түргэвчилсэн худалдан авалтын горим бий болгож, шуурхай хэрэгжилтийг дэмжих.

Энэхүү зохицуулалт нь стратегийн бүтээгдэхүүний хангамжийн тасалдлын эрсдэлийг бууруулж, импортын хамаарлыг шат дараатайгаар багасгах, ил тод мэдээлэлд суурилсан хяналт-шинжилгээний нэгдсэн системийг бүрдүүлэх хууль эрх зүйн тогтвортой үндэс болно. Ингэснээр Монгол Улс шаталсан зорилтоо биелүүлж, 2027 оноос 45 хоногийн бодит нөөцийн түвшинд хүрэх, цаашид олон улсын жишигт нийцэх 60 хоногийн стратегийн зорилт руу алхах нөхцөл бүрдэнэ.

7.3 Санхүүжилт ба зах зээлийн хөшүүрэг:

- Репо болон баталгаат санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжүүлж, нөөц бүрдүүлэх зориулалттай зээл, баталгааг бага хүүтэйгээр олгоно.
- Төрийн баталгаа, үнэт цаас ашиглан дэд бүтэц, агуулах, логистикийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- Татварын зорилтот урамшуулал - стандарт хангасан сав, насос, хэмжилтийн төхөөрөмж, дижитал системийн хөрөнгө оруулалтад элэгдэл түргэвчлэх, НӨАТ-ын хөнгөлөлт үзүүлэх.
- Эх үүсвэрийн төрөлжилт - ОХУ-ын төвлөрлөөс хамаарал бууруулж, БНХАУ болон бүс нутгийн бусад ханган нийлүүлэгчидтэй урт хугацааны гэрээ байгуулах.

7.4 Хүний эрх, нийгмийн хамгаалал: Хууль нь дараах үндсэн эрхийг хангахад чиглэнэ:

- Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх;
- Эдийн засгийн амьдралд оролцох, хөдөлмөрийн боломжийг дэмжих;
- Хэрэглээний үнийн тогтвортой байдлаар дамжуулан өрхийн амьжиргааг хамгаалах;
- Алслагдсан бүс нутгийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Ажлын байр бий болгож, жендерийн тэгш оролцоог хангах.

7.5 Хэрэгжилтийн үе шат, хяналт-шинжилгээ:

- Богино хугацаа (0–6 сар): хууль батлах, нөөцийн норм, хариуцлагын матриц, платформын техникийн даалгавар боловсруулах.
- Дунд хугацаа (6–24 сар): дижитал платформ ашиглалтад орж, бүсчилсэн агуулах байгуулах, 45 хоногийн нөөцийн зорилт биелүүлэх.
- Урт хугацаа (24 сар+): дотоод боловсруулах чадавх нэмэгдүүлэх, 60 хоногийн стандарт руу шилжих.

KPI Key Performance Indicator ба үнэлгээ: KPI (Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт) нь хууль, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагааны үр дүнг тоон болон чанарын хэмжүүрээр үнэлэх үзүүлэлт юм. Эдгээр үзүүлэлт нь зорилт хэрхэн биелж байгааг тодорхойлж, хэрэгжилтийг хянах, дүгнэх, сайжруулахад ашиглагдана. KPI нь хуулийн хэрэгжилтийн бодит ахиц, үр нөлөөг тодорхой харуулж, ил тод, хариуцлагатай хэрэгжилтийг хангах гол хэрэгсэл болно.

Хэрэгжилтийг үнэлэх үндсэн үзүүлэлтүүд:

- Нөөцийн хоног – стратегийн бүтээгдэхүүний нөөц хэдэн хоног хүрэлцээтэй байгааг хэмжинэ;
- Импортын төвлөрлийн индекс (НИИ) – нийлүүлэлт цөөн эх үүсвэрээс хэт хамааралтай байгаа эсэхийг харуулна;
- Санхүүжилтийн өртөг – нөөц бүрдүүлэх, хадгалах, эргэлтийн хөрөнгийн зардлын түвшинг илтгэнэ;
- Үнийн хэлбэлзлийн индекс – шатахуун, түлшний үнийн савлагаа, тогтвортой байдлыг хэмжинэ;
- Тайлагналын ил тод байдлын түвшин – мэдээлэл, хяналт, тайлангийн ил тод, хүртээмжтэй байдлыг үнэлнэ.

KPI нь хуулийн хэрэгжилтийн ахиц дэвшлийг тооцох, эрсдэлийг эрт илрүүлэх, шийдвэр гаргалтыг нотолгоонд тулгуурлуулах чухал хэрэгсэл юм. Эдгээр

үзүүлэлтийг улирал, жил тутам үнэлж, хууль хэрэгжилтийн бодит үр дүнг ил тод мэдээлж байх нь үр нөлөөтэй бодлого хэрэгжилтийн үндэс болно.

7.6 Дүгнэлт. Энэхүү хуулийг баталж хэрэгжүүлснээр:

- Импортын хамаарал буурч, 30-45 хоногийн стратегийн нөөц бүрдэнэ;
- Хангамжийн тасалдал, үнийн савлагааны эрсдэл буурна;
- Хүний эрх, эдийн засгийн аюулгүй байдал, хэрэглэгчийн эрхийн баталгаа сайжирна;
- Мэдээлэл, хяналт, шийдвэр гаргалт ил тод, датад суурилсан болно;
- Эдийн засгийн тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлыг дэмжих урт хугацааны суурь нөхцөл бүрдэнэ.

-oOo-

Тандан судалгааны тайлбар:

1.ASEAN-ийн зарим орон гэдэг нь Зүүн Өмнөд Азийн орнуудын (ASEAN — *Association of Southeast Asian Nations*) гишүүн орнуудын шатахуун, газрын тосны бүтээгдэхүүний **нөөцлөлтийн бодлого, эрх зүйн зохицуулалт харилцан адилгүй** байдгийг илэрхийлж байгаа юм. Тайлбарлавал: Тайланд, Вьетнам, Сингапур, Индонез, Малайз,

тн Тайланд- Тайландын “Oil Fuel Fund” (OFFO) болон “Energy Policy and Planning Office (EPPO)” нь улсын шатахуун нөөцийн зохицуулалтыг хариуцдаг. Нөөцийн доод түвшин: ~25 хоногийн хэрэглээнд хүрэлцэх хэмжээтэй байх ёстой гэж хуульчилсан.

Онцлог: Нөөцлөлтийн санг төрийн оролцоотой “шатахууны сан”-гаар дамжуулан удирддаг.

Эх сурвалж: <https://www.eppo.go.th>

vn Вьетнам: “Decree No. 83/2014/ND-CP” хуулиар шатахууны худалдаа, импорт, нөөцлөлтийн доод түвшинг тогтоосон. Зорилт: Нийлүүлэлтийн тасалдалд бэлтгэхийн тулд 90 хоногийн нөөц бүрдүүлэх зорилт дэвшүүлсэн. Онцлог: Төр-хувийн хэвшлийн хамтын нөөцлөлтийн систем (Petrolimex, PV Oil зэрэг компаниуд). Эх сурвалж: <https://moit.gov.vn>

sg Сингапур: Дэлхийн хамгийн том шатахуун экспортлогч, боловсруулалтын төв боловч төрийн стратегийн нөөц байхгүй. Онцлог: Сингапур нь зах зээлд тулгуурласан (market-based) тогтолцоотой — нөөцлөлт, хангамжийг компаниуд өөрсдөө зохицуулдаг. Төр нь зөвхөн татвар, стандартаар зохицуулалт хийдэг, нөөцийн албан үүрэг тавьдаггүй. Эх сурвалж: <https://www.ema.gov.sg>

id Индонез: “Oil and Gas Law No. 22/2001” хуулиар шатахууны нөөцийн доод түвшин, онцгой үеийн зохицуулалт тусгагдсан. Онцлог: Pertamina төрийн өмчит компани нь импорт, нөөцлөлт, түгээлт, онцгой хариу арга хэмжээ бүгдийг гүйцэтгэдэг. Эх сурвалж: <https://www.esdm.go.id>

мү Малайз: “Petroleum Development Act 1974” болон “National Energy Policy”-ийн дагуу нөөцлөлтийн бодлого хэрэгждэг. Нөөцийн бодлого: 30 хоногийн импортын тэнцвэртэй нөөцтэй байх. Онцлог: Петронас компани төрийн өмчит, бүх шатны хангамж, экспортыг хариуцдаг. Эх сурвалж: <https://www.petroleum.gov.my>

Дүгнэлт: ASEAN-ийн орнуудын дунд:

- Нөөцлөлтийн хугацаа, зохицуулалт харилцан адилгүй (25–90 хоногийн хооронд),
- Төр-хувийн хосолсон менежмент түгээмэл,
- Сингапурын жишээ — зах зээлийн механизмд тулгуурласан, төрийн албан нөөц байхгүй цорын ганц загвар,
- Вьетнам, Тайланд — хуульчилсан нөөцийн доод түвшинтэй,
- Индонез, Малайз — төрийн өмчит компаниар дамжуулан хэрэгжүүлдэг,
- гэж ялгаатай.

Эх сурвалжууд:

- ASEAN Centre for Energy (ACE)
- Energy Policy and Planning Office (Thailand)
- Ministry of Industry and Trade (Vietnam)
- Energy Market Authority (Singapore)
- Ministry of Energy and Mineral Resources (Indonesia)
- Petronas – Malaysia Official Energy Portal

2. “Этапчилсан” гэдэг үг нь орос хэлний “этап” (этапный, этапировать) гэдэг үгнээс гаралтай бөгөөд “шат дараатай, үе шаттай, алхамчилсан” гэсэн утгатай байдаг. Тайлбар Этап — үе шат, шат, дамжлага Этапчилсан — үе шат бүрээр төлөвлөсөн, шат дараатайгаар хэрэгжүүлэх гэсэн утгатай. Жишээ: “Этапчилсан хэрэгжилт” — үе шаттай хэрэгжүүлэх (жишээ нь: I үе шат – хууль батлах, II үе шат – туршилт хэрэгжүүлэх, III үе шат – бүрэн хэрэгжилт гэх мэт)

1. IEA — International Energy Agency (Олон улсын эрчим хүчний агентлаг) 1974 онд байгуулагдсан, OECD-ийн харьяа олон улсын байгууллага.

Гол зорилго нь:

- Гишүүн орнуудын газрын тос, эрчим хүчний аюулгүй байдлыг хамгаалах,
- Түүхий тосны нийлүүлэлтийн тасалдлын үед нөөц ашиглах хамтарсан механизм бүрдүүлэх.

IEA-ийн үндсэн шаардлага: Гишүүн орон бүр 90 хоногийн импортын хэрэглээнд хүрэлцэх стратегийн газрын тосны нөөцтэй байх ёстой. Нөөц нь улсын болон хувийн хэвшлийн аль алинд байж болно, гэхдээ хууль, журмаар баталгаажсан байх ёстой. Мөн ил тод тайлагнал, хяналт-шинжилгээ, онцгой нөхцөлийн хариу арга хэмжээний протокол-той байх шаардлагатай.

Эх сурвалж: IEA Oil Security and Emergency Response

eu EX — Европын Холбооны шатахуун нөөцийн зохицуулалт: EX нь “Council Directive 2009/119/EC” баримтаар гишүүн орнуудыг 90 хоногийн газрын тосны нөөцтэй байх үүрэгтэй болгосон.

Энэхүү тогтолцоо нь дараах гурвалсан зарчим дээр тулгуурладаг:

1. Хуульд тулгуурласан нөөцийн доод түвшин

→ 90 хоногийн импортын хэмжээгээр нөөц бүрдүүлэх үүрэг.

2. Тайлагнал, хяналтын систем→ Гишүүн орнууд сар бүр Европын Комисст нөөцийн мэдээллээ илгээдэг.

3. Хариу арга хэмжээний протокол→ Тасалдал гарсан үед нөөцөө гаргах, гишүүн орнууд хоорондоо хамтран нөхөх механизм.

Эх сурвалж: EU Directive 2009/119/EC

Жишээ хэрэглээ:

- EU energy security framework → EX-ны эрчим хүчний аюулгүй байдлын хүрээ
- EU oil stock directive (2009/119/EC) → EX-ны газрын тосны нөөцийн тухай зөвлөмж (журам)
- EU member states must maintain a minimum 90-day oil reserve → EX-ны гишүүн орнууд 90 хоногийн газрын тосны нөөцтэй байх ёстой.

Репо арилжаа = Түр хугацааны санхүүжилт + Үнэт цаасны барьцаа + Буцаан худалдан авах нөхцөл.

Давуу тал: Санхүүжилтийн өртөг багатай, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлдэг.

Шатахууны бодлогод хэрэглэх зорилго: Импортлогч аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн дарамтыг бууруулах, нөөц бүрдүүлэлтийг дэмжих.

Сценари гэдэг нь “ямар нэгэн нөхцөл байдалд юу болох вэ?” гэсэн урьдчилан таамагласан хувилбар юм.

Тухайлбал: Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн бодлогод:

- Бага эрсдэлийн сценари: нийлүүлэлт хэвийн, үнэ тогтвортой, нөөц хүрэлцээтэй.
- Дунд эрсдэлийн сценари: экспортлогч оронд квот тогтох, үнэ бага зэрэг өсөх.
- Өндөр эрсдэлийн сценари: экспортын хориг, хил хаагдах, үнэ огцом өсөх.

БУФЕР ГЭЖ: эрсдэл, савлагаа, гэнэтийн өөрчлөлтөөс хамгаалж, тогтвортой байдлыг хадгалах зорилготой түр хамгаалалт эсвэл дунд үе шатны дэмжлэгийн систем юм.

Эдийн засгийн буфер:

→ валютын ханш, шатахууны үнэ, гадаад зах зээлийн савлагаанаас үүдэх эрсдэлд бэлтгэсэн санхүүгийн нөөц, тогтворжуулалтын сан.

Хангамжийн буфер

→ нийлүүлэлт тасалдсан үед богино хугацаанд дотоод хэрэглээг хангах бэлэн нөөцийн хэмжээ (жишээ нь 30 хоногийн нөөц).

Репо гэрээ (Repurchase Agreement) гэдэг нь: Богино хугацааны санхүүжилтийн хэлбэр бөгөөд нэг тал (жишээ нь банк, эсвэл компанийн эзэмшигч) өөрийн үнэт цаасыг түр хугацаанд зараад, тодорхой хугацааны дараа дахин худалдан авах амлалттайгаар хөрөнгө босгодог гэрээ юм.

Ямар зорилготой вэ? Санхүүгийн байгууллага эсвэл компани түр хугацаанд бэлэн мөнгөний урсгал хэрэгтэй үед (жишээ нь шатахууны нөөц бүрдүүлэх, хөрөнгө эргэлтэд оруулах гэх мэт) үнэт цаасаа барьцаалан зээл авдаг. Харин хөрөнгө нийлүүлэгч тал (жишээ нь Монголбанк, арилжааны банк) баталгаатай, эрсдэл багатай зээл олгодог.

Жишээ: Монголбанк шатахууны хангамжийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор арилжааны банкнуудад “репо санхүүжилт” олгож болно. Банк энэ мөнгийг шатахуун импортлогчдод бага хүүтэй зээл хэлбэрээр дамжуулна. Тодорхой хугацааны дараа зээлдэгч (банк) үнэт цаасаа буцаан худалдаж авч, репо гэрээг хаана.

Давуу тал:

- ✓ Хүү бага (төв банкны бодлогын хүүтэй уялддаг);
- ✓ Эдийн засгийн эргэлтийг дэмждэг;
- ✓ Эрсдэл бага, богино хугацаанд гүйцэтгэгддэг;

Товч тайлбар: Репо = Түр хугацааны барьцаат санхүүжилт.

Нэг тал үнэт цаасаа барьцаалж мөнгө авна → хугацаа дуусмагц дахин худалдан авч гэрээг хаадаг.

KPI - Key Performance Indicator (Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт) нь хууль, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагааны үр дүнг тоон болон чанарын хэмжүүрээр үнэлэх үзүүлэлт юм.

Тайлбар:

- ✓ Key — чухал, гол;
- ✓ Performance — гүйцэтгэл, үр дүн;
- ✓ Indicator — үзүүлэлт, хэмжүүр.

Иймээс “Key Performance Indicator (KPI)” гэдэг нь бодлого, хөтөлбөр, байгууллагын зорилт биелэлтийг хэмжих гол үзүүлэлт гэсэн утгатай болно.

-ooOoo-

**“СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ХАНГАМЖ, НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ”
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	3
ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ	
СОНГОСОН БАЙДАЛ.....	3
ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН	
БАЙДАЛ.....	4
3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр	
нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	4
3.2.“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг	
нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	4
3.3.“Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр	
нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	5
ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ	
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	6
4.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	6
4.2.“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн	
байдал.....	8
4.3.“Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн	
үнэлгээ.....	8
ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ.....	9
5.1.Дүгнэлт, зөвлөмж.....	9

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад заасны дагуу Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулах болон хуулийн төслийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөхд;
5. Дүгнэлт, зөвлөмж өгөх.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл нь 3 бүлэг 11 зүйлтэйгээр боловсруулагдсан бөгөөд доорх агуулгыг тусгасан байна. Үүнд:

- Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэгт нийтлэг харилцаа буюу хуулийн зорилт, холбогдох хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, үйл ажиллагаанд баримтлах зарчим болон стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний талаар тусгасан байна.
- Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих хүрээнд Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Монголбанкны хэрэгжүүлэх бүрэн эрх болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зохицуулалтыг тусгасан байна.
- Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт бусад зохицуулалт буюу хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага болон хуулийн үйлчлэх хугацааг тусгасан байна.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах шалгуур үзүүлэлтүүдийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Практикт хэрэгжих боломж.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл болон түүний зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдсан болон бодит үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал,

хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь төслийн зорилгыг хангахад чиглэсэн болоод хүргэх боломжтой эсэхийг үнэлнэ.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг судлан үзсэний үндсэн дээр хуулийн төслөөс түүний зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, зорилгыг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс тус хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах зорилгоор хуулийн төслийг бүхэлд нь сонгож үнэлсэн болно.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл учраас хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллагыг тодорхойлоход бусад улс орнуудын туршлага, урд өмнө хэрэгжүүлж байсан ижил төстэй арга хэмжээнүүдийн үр дүн, туршлагыг жишиг болгон ашигласан болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийсэн.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн зорилго нь олон улсын худалдааны нөхцөл байдал, гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан дотоодын зах зээл дээр стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн болох шатахууны хангамж нийлүүлэлтэд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, тасалдал хомстлоос урьдчилан сэргийлэх, даван туулах арга хэмжээг тодорхойлох, нөөцийг бүрдүүлэх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэ зорилгод хүрэхийн тулд дараах зарчим, арга хэмжээг дэвшүүлсэн байна. Үүнд:

- ✓ үндэсний язгуур ашиг сонирхлыг эрхэмлэх;
- ✓ гадаад худалдааны алдагдлыг бууруулах, худалдааг хөнгөвчлөх;
- ✓ шуурхай, хариуцлагатай байх;
- ✓ шударга, ил тод байх зарчмыг баримтлах.

3.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгасан болно.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллагыг тодорхойлоход бусад улс орнуудын туршлага, урд өмнө хэрэгжүүлж байсан ижил төстэй арга хэмжээнүүдийн үр дүн, туршлагыг жишиг болгон ашигласан болно.

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

№	Шалгуур үзүүлэлт	Шалгах хэрэгсэл
1	“Зорилгод хүрэх байдал”	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	“Ойлгомжтой байдал”	Ойлгомжтой байдлыг шалгах
3	“Практикт хэрэгжих боломж”	Практик турших

4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.

Зорилгод хүргэх байдал шалгуур үзүүлэлтээр үр нөлөөг үнэлэхдээ хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах болсон зорилго, түүнийг батлан гаргах хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байдлыг хуулийн төсөлд тусгасан байдалтай харьцуулж, дүн шинжилгээг хийв.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлалд дараах хууль зүйн үндэслэлүүдийг тусгасан байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн¹ тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн² 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Засгийн газар нь эдийн засгийн харилцааг аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийн сонирхолд нийцүүлэн зохицуулж, шударга өрсөлдөөнийг дэмжин дангаар ноёрхлыг хязгаарлах, эдийн засгийн тэнцвэрийг сайжруулах арга хэмжээ авна.” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.” гэж;

2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор³ баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992 он, №01

² Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1993 он, №03

³ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2024 он, №35

ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.3.1.9-д Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна." гэж;

3.Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 98 дугаар тогтоолоор баталсан "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийн 4.3.2-т "Евро-5" стандартад нийцсэн чанарын шаардлага хангасан шатахууны импорт, хэрэглээг дэмжих, стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг импортоор оруулах, хэрэглэхийг үе шаттайгаар хориглох, шатахууны чанарын хяналтын тогтолцоог сайжруулах; гэж, Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийн 5.2-ын 118-д "Евро-5" стандартад нийцсэн шатахууны эзлэх хувийг 2025 онд 80 хувьд хүргэнэ," гэж;

4.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 4.2-т "Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно" гэж тус тус заасан байна.

Дээрх үндэслэлүүд нь Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийг батлан гаргах хэрэгцээг оновчтой илэрхийлсэн байна.

Түүнчлэн хуулийн төслийн үзэл баримтлал боловсруулах практик шаардлагын хэсэгт холбогдох статистик, тоо мэдээнд үндэслэн Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг хангахад үүсээд байгаа өнөөгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийг зорьсон байна.

Тухайлбал, манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд нийт импортын 95 орчим хувийг ОХУ, үлдсэн хувийг БНХАУ эзэлж байна. Газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын Засгийн газар болон нийлүүлэгч компаниудаас тус улсын дотоодын зах зээлийн нөхцөл байдал, үйлдвэрийн процесс, төлөвлөгөөт ажилтай холбоотойгоор гаргасан экспортын хориг, нийлүүлэлтийг бууруулах зэрэг арга хэмжээнүүд нь манай улсын шатахууны хангамжийн тогтвортой байдалд шууд нөлөөлж, тасалдал хомсдол үүсгэн, эрэлтийг нэмэгдүүлэн, үнийн хэлбэлзлийг бий болгож ирсэн байна. Түүнчлэн иргэдийн өргөн хэрэглээний Аи-92 автобензинийн хэрэглээ 2024 онд сард дунджаар 60,0 мянган тонн байсан бол 2025 онд сард дунджаар 80 мянган тонн хүрсэн бөгөөд ОХУ-ын "Роснефть" компанитай хийсэн хэлэлцээр, гэрээний хүрээнд 705,0 ам.долларын тогтмол үнээр нийлүүлж буй энгийн Аи-92 автобензинийн хэмжээ нь 60,0 мянган тонноор хязгаарлагдаж, нэмэгдүүлэх боломжгүй нөхцөл байдалтай байгаа тул үлдсэн 20,0 мянган орчим тонн Евро-5 ангиллын Аи-92 автобензинийг БНХАУ-аас олон улсын зах зээлийн үнээр худалдан авахаас аргагүй байдал үүсээд байна.

Иймээс шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангахтай холбогдуулан улсын хэмжээнд 30-аас доошгүй хоногийн тогтмол нөөцтэй байх зорилтын хүрээнд импортлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, нөөцийг бүрдүүлэх, хадгалах савны хүчин чадал, багтаамжийг нэмэгдүүлэх, бодит шаардлага зүй ёсоор тулгарч байгаа зэрэг нь Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийг батлан гаргах практик хэрэгцээг оновчтой илэрхийлсэн байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд туссан хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалын 2 дахь буюу “Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ” хэсэгт “Энэ хуулийн төсөл нь олон улсын худалдааны нөхцөл байдал, гадаад хүчин зүйлээс сэргийлэх, стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, даван туулах арга хэмжээг тодорхойлох, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой” гэж тодорхойлжээ.

Иймд бие даасан хуулийн төсөл боловсруулах болсон үзэл баримтлалын үндсэн агуулга нь уг хуулийн төслийн зорилготой нийцсэн байна гэж үзэв.

4.2. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ.

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд төсөлд холбогдох байгууллагаас тусгайлан санал ирээгүй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан “Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага”, 30 дугаар зүйлд заасан “Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага хангасан эсэх” мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг судалж үнэллээ.

Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага		
Шалгах асуулт		Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.Хуулийн төслийн агуулга дараах нийтлэг шаардлага хангасан байна: 29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Тийм
2	29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Тийм
3	29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Тийм
4	29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Тийм
5	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Тийм
6	29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Тийм
7	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш	Тийм

	татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	
8	29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Тийм
9	29.2.Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана.	Тийм

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан байна гэж үзэв.

Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага		
Шалгах асуулт		Шаардлагыг хангасан эсэх
1	30.1.Хуулийн төслийн хэл зүй, найруулга дараах нийтлэг шаардлагыг хангасан байна: 30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Тийм
2	30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Тийм
3	30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Тийм
4	30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Тийм
5	30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Тийм

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан байна.

Дээрх байдлаар хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд хуулийн төсөл нь нийтлэг байдлаараа хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан байна гэж үзэв.

4.3.“Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.

Энэхүү хуулийн хүрээнд олон улсын худалдааны нөхцөл байдал, гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан дотоодын зах зээл дээр стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн (керосин, дайвар бүтээгдэхүүнээс бусад бүх төрлийн шатахуун, алт)-ий хангамж нийлүүлэлтийг дэмжих, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, даван туулах арга хэмжээг тодорхойлох, холбогдох шийдвэрийг шуурхай гаргахтай холбогдсон харилцааг зохицуулах хүрээнд холбогдох зохицуулалтуудыг нарийвчлан тодорхойлсон учир талуудад хүлээн зөвшөөрөгдөх байдлын хувьд холбогдох шаардлагыг хангасан байна.

2025 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 126 дугаар тогтоолоор 2026 оны газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 70 аж ахуйн нэгж нөөцийн хэмжээг Аи-92 автобензин 64,500 тонн, Аи-95/98 автобензин 1,280 тонн, дизелийн түлш 120,500 тонн, Онгоцны түлш /ТС-1/ 6,200 тонн, шингэрүүлсэн шатдаг хий 3,400 тонн байхаар батлагдаж үүрэг хүлээлгэсэн. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн хэвийн үйл ажиллагааг хангахын тулд Роснефть компаниас ирүүлсэн 11 дүгээр сарын хил үнийг харгалзуулан үзэхэд сард дунджаар 500 орчим тэрбум төгрөг буюу 140 орчим сая ам.долларын эргэлтийн хөрөнгө шаардлагатай байна.

2022 онд нийт 17 аж ахуйн нэгжид 400 орчим тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийг 16 хувийн хүүтэйгээр олгож, зээлүүд бүрэн, амжилттай эргэн төлөгдсөн байна.

Мөн 2022 оноос ОХУ болон Украйны хооронд зэвсэгт мөргөлдөөн эхэлснээс шалтгаалан дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ огцом өсч, нэг баррель нь 141 ам.долларт хүрсэн. Үүнтэй холбоотойгоор ОХУ-ын нийлүүлэгч тал Аи-92 автобензинийг тогтвортой нийлүүлэхийн тулд гурван сарын урьдчилсан төлбөрийг хил үнийг 815 ам.доллараар төлөх шаардлага тавьсан эрсдэл үүсгэж байсан.

Иймд шатахууны салбарт тогтвортой байдлыг хангах, тасалдлаас сэргийлэх зорилгоор холбогдох хууль, зохицуулалтыг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

№	“Практикт хэрэгжих боломж”-ын шалгуур үзүүлэлтүүд	Хариулт
1	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх	Тийм
2	Тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэх	Тийм

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1. Дүгнэлт, зөвлөмж.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ. Энэхүү хуулийн төсөлд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу холбогдох судалгаа хийгдсэн тул энэхүү судалгааны дүгнэлт, хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулах шаардлагатай.

Зорилгод хүрэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлалаас дөрвөн төрлийн зорилгыг тодорхойлж, эдгээр зорилгод хуулийн төслийн зүйл заалт хэрхэн нийцэж байгаад үнэлгээ хийсэн. Үнэлгээний дагуу хуулийн төслийн зорилго нь төслийг боловсруулах

болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан гэж үзэж байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага хангасан эсэх, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг судалсан.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан бөгөөд Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан байна.

Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төсөлд олон улсын худалдааны нөхцөл байдал, гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан дотоодын зах зээл дээр стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн (керосин, дайвар бүтээгдэхүүнээс бусад бүх төрлийн шатахуун, алт)-ий хангамж нийлүүлэлтийг дэмжих, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, даван туулах арга хэмжээг тодорхойлох, холбогдох шийдвэрийг шуурхай гаргахтай холбогдсон харилцааг зохицуулах хүрээнд УИХ, Засгийн газар, Монголбанкны бүрэн эрх болон Орон нутгийн төрийн захиргааны байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой тусгаж өгсөн байна.

Мөн тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа тул практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

--- ооо ---

СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХАНГАМЖ, НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

ЗАРДЛЫН ТООЦООНЫ АГУУЛГА:

1. Үндэслэл
2. Төрийн байгууллагад үүсэх зардал
3. Хуулийн этгээдэд үүсэх зардал
4. Иргэнд үүсэх зардал
5. Товч дүгнэлт

1. Үндэслэл:

Хууль зүйн үндэслэл: Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан бол Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Засгийн газар нь эдийн засгийн харилцааг аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийн сонирхолд нийцүүлэн зохицуулж, шударга өрсөлдөөнийг дэмжин, эдийн засгийн тэнцвэрийг сайжруулах арга хэмжээ авна” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан байна.

Эдгээр заалтыг үндэслэн, стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн ялангуяа газрын тосны бүтээгдэхүүн нь улсын эдийн засгийн аюулгүй байдал, дэд бүтцийн тогтвортой байдал, иргэдийн амьдралын чанарт шууд нөлөөтэй гэж үзэх хууль зүйн үндэслэл бүрдэж байна. Мөн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.9-д газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэх зорилт, 2025 оны 126 дугаар тогтоолоор 195,880 тонн шатахууны нөөц бүрдүүлэх үүргийг тус тус тодорхойлсон нь уг хуулийн хэрэгцээ, үндэслэлийг хууль тогтоомжийн түвшинд баталгаажуулж байна

Эдийн засгийн ба практик үндэслэл: Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100 хувь импортоор хангадгаас, 95 орчим хувийг ОХУ-аас, үлдсэн хэсгийг БНХАУ-аас импортлодог. Энэ нь эдийн засгийн хамаарал, валютын эрсдэл, үнийн тогтворгүй байдал, нийлүүлэлтийн тасалдлын эрсдэл бий болгож байна.

- 2021–2024 онд олон улсын шатахууны үнэ болон ОХУ-ын экспортын бодлогын өөрчлөлтөөс шалтгаалан:

- 2021 онд Аи-92 автобензин тасалдсан;

- 2023 онд ОХУ шатахуун экспортлохыг хориглосноор Монгол Улс 21 хоногийн турш шатахуун импортгүй болсон;

- 2025 онд Аи-92 автобензиний сарын хэрэглээ 80 мянган тонн хүрч, ОХУ-аас нийлүүлж буй 60 мянган тонн хязгаарлагдсан нөхцөл байдал үүссэн.

Эдгээр үзүүлэлтүүд нь дотоодын хангамжийг хамгаалахын тулд төрийн оролцоо, нөөц бүрдүүлэлт, санхүүгийн дэмжлэг, мэдээллийн хяналтын систем шаардлагатай байгааг харуулж байна.

Олон улсын нөхцөл байдал ба гадаад хүчин зүйл: 2025 онд АНУ-ын Ерөнхийлөгчийн “Харилцан тэнцвэртэй тарифыг ногдуулах тухай захирамж”-аар эхэлсэн худалдааны зохицуулалтын шинэ үе шат нь дэлхий даяар импортын тариф нэмэгдэх, зах зээлүүдийн тодорхой бус байдал өсөх, шатахуун, ховор металл, эрчим хүчний үнийн савалгаа нэмэгдэх нөхцөл үүсгэсэ, үүний улмаас дэлхийн худалдаа, нийлүүлэлтийн сүлжээ тасалдаж, энергийн бүтээгдэхүүний үнэ болон нөөцийн тогтвортой байдал улс орнуудын үндэсний аюулгүй байдлын бодлогод нэн чухал байр суурь эзэлж байна. Монгол Улсын хувьд газрын тосны импортоос 95%-ийн хамааралтай байгааг харгалзан үзвэл энэхүү эрсдэл эдийн засгийн ноцтой хүчин зүйл болж байна.

Хууль боловсруулах зайлшгүй шаардлага: Дээр дурдсан хууль зүйн болон эдийн засгийн үндэслэл, олон улсын нөхцөл байдлын нөлөөгөөр Монгол Улсын хувьд дараах зайлшгүй бодлогын шаардлага үүссэн байна:

- Газрын тосны бүтээгдэхүүний 30 хоногийн нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжүүдэд репо арилжааны нөхцөлөөр хөнгөлөлттэй санхүүжилт олгох;
- Газрын тосны агуулах, дэд бүтцийг өргөтгөх, шинэчлэх хөрөнгө оруулалтын урамшуулал бий болгох;
- Мэдээллийн ил тод байдлыг хангах, хангамжийн хяналтын нэгдсэн систем нэвтрүүлэх;
- Гадаад худалдааны эрсдэлийг бууруулах, валютын нөөцийн бодлогыг уялдуулах шаардлагатай байна.

Хүлээгдэж буй үр дүн: Хууль батлагдсанаар дараах бодит үр нөлөөг авчирна:

- Шатахууны хангамж тасалдах эрсдэл 60–70% буурна
- Нөөцийн хоног 30 → 45 хоног
- Бодлогын хүүгийн хөнгөлөлтөөр аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн дарамт буурна
- Иргэдийн амьжиргаанд үнийн тогтвортой байдлын нөлөө үзүүлнэ.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, төлбөрийн тэнцэл, хангамжийн тогтвортой байдал, бодлогын үр ашигт нэгдсэн зохицуулалт хийхэд чиглэсэн хууль зүйн болон эдийн засгийн үндэслэл бүхий бодит шаардлагын үр дүн юм.

2. Төрийн байгууллагад үүсэх зардал:

№	Зардлын төрөл	Хаана, ямар байгууллагад	Урьдчилсан зардал (сая ₮)	Юунд зориулагдах вэ / Үндэслэл
1	Хууль хэрэгжүүлэх бүтэц байгуулах	Засгийн газар, Аж үйлдвэр ба эрдэс баялгийн яам, Сангийн яам, Монголбанк, Орон нутгийн захиргаа		Хуулийг хэрэгжүүлэх бүтэц, нэгж байгуулж, орон тоо нэмэх, хяналт тавих чиг үүрэг бүхий хэлтэс байгуулах.
2	Мэдээллийн нэгдсэн систем байгуулах	Аж үйлдвэр ба эрдэс баялгийн яам, Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар, Монголбанк		Импорт, нөөц, агуулах, үнэ, түгээлтийн мэдээллийг нэгтгэх цахим систем (платформ) байгуулах; сервер, программ, мэдээллийн хамгаалалт хийх.
3	Хяналт, үнэлгээний систем	Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, Аж үйлдвэр ба эрдэс баялгийн яам		Хуулийн хэрэгжилтийн үр дүнг хэмжих систем бий болгох. Жишээлбэл: нөөцийн хоног, импортын төвлөрлийн индекс, үнэ, хүү, хангамжийн мэдээлэл.
4	Сургалт, чадавх бэхжүүлэх	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд, Орон нутгийн захиргаа		Хуулийн хэрэгжилт, стандарт, ил тод байдал, хяналт-шинжилгээний талаар төрийн ажилтнуудад сургалт явуулах.
5	Аудит ба ил тод байдлын зардал	Төрийн аудитын байгууллага, Сангийн яам, Монголбанк		Хуулийн хэрэгжилтийн явцын аудит, тайлан гаргах, ил тод байдлыг хангах, цахим тайлагнал хийх.
6	Эрсдэлийн нөөцийн сан байгуулах	Сангийн яам, Монголбанк		Импорт тасалдах, дэлхийн үнэ хэлбэлзэх үед дотоод зах зээлийг хамгаалах зориулалттай түр "буфер сан" (эрсдэлийн сан) бүрдүүлэх.
			Нийт 0 төгрөг (урьдчилсан байдлаар)	2025–2027 онд үе шаттайгаар хэрэгжүүлэх төлөвлөгөөний зардал.

Тайлбар:

- Зардлын тооцоолол нь хуулийн 6–9 дүгээр зүйлүүдэд заасан төрийн үүрэг, хэрэгжилтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах үндсэн хөрөнгө оруулалт, программ, хүний нөөцийн зардлыг хамарна.

- Төсвийн хэрэгжилтийг 2025–2027 онд үе шаттайгаар хуваарилж, улсын төсөв, Монголбанкны репо болон олон улсын хамтын ажиллагааны эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжтой.

- Энэхүү зардал нь төрийн байгууллагууд хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах үндсэн хөрөнгө оруулалт, мэдээллийн систем, хүний нөөц, сургалт, хяналт, болон онцгой нөхцөлд хэрэглэх санг хамарна.

- Зардлыг улсын төсөв, Монголбанкны санхүүжилт, мөн олон улсын байгууллагын дэмжлэгээр үе шаттайгаар гаргах боломжтой.

- Хууль хэрэгжсэнээр төрийн хяналт, мэдээллийн ил тод байдал, шатахуун болон стратегийн бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдал сайжирна.

3. Хуулийн этгээдэд үүсэх зардал

№	Зардлын төрөл	Хаана, ямар аж ахуйн нэгжид	Урьдчилсан зардал (сая ₮)	Юунд зориулагдах вэ / Үндэслэл
1	Нөөц бүрдүүлэх хөрөнгө оруулалт	Импортлогч, түгээгч, боловсруулах үйлдвэр, агуулах эзэмшигч ААН		Хуулийн дагуу 30–45 хоногийн шатахуун, түлшний нөөц бүрдүүлэхэд шаардагдах эргэлтийн хөрөнгийн өсөлт, агуулах, хадгалах хүчин чадлыг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалт.
2	Мэдээллийн системд холбогдох зардал	Импортлогч, түгээгч, агуулах, хяналтын байгууллагад холбогдсон ААН		Төрийн мэдээллийн нэгдсэн платформд холбогдох, мэдээлэл илгээх, API суурилуулах, техникийн тохируулга хийх, цахим тайлагналын системд оролцох зардал.
3	Стандарт, чанар, аюулгүй ажиллагааны шинэчлэл	Шатахуун түгээх станц, агуулах, тээвэрлэгч ААН		Олон улсын (EN, ISO, API) стандартуудыг нэвтрүүлэх, хэмжилтийн төхөөрөмж, насос, савны шинэчлэл, аюулгүйн системийн хөрөнгө оруулалт.
4	Сургалт, аудит, тайлагналын зардал	Томоохон импортлогч, жижиг түгээгчид		Хууль хэрэгжилтийн сургалт, тайлагнал, аудитын зардал, мэдээллийн ил тод байдлын шаардлагад нийцүүлэх дотоод хяналтын систем байгуулах.
5	Санхүүжилтийн өртөг ба хүүгийн дарамт	Нөөцийн сан бүрдүүлэлтэд оролцогч бүх ААН		Нөөц бүрдүүлэхэд зориулсан зээлийн хүүгийн зардал (жилийн 10–12% хүүтэй репо эсвэл баталгаат санхүүжилтийн шугам ашиглах нөхцөлд тооцсон).
6	Даатгал эрсдэлийн хамгаалалтын зардал ба	Импортлогч, агуулах, тээвэрлэгч ААН		Хадгалалт, тээвэрлэлтийн явцад үүсэх алдагдал, онцгой нөхцөл (гал, осол, тасалдал)-ын эрсдэлийг даатгуулах, буфер системийн даатгалд хамрагдах.
			Нийт 0 төгрөг (урьдчилсан байдлаар)	2025–2030 онд үе шаттайгаар хэрэгжүүлэх дундаж зардлын тооцоо.

Тайлбар: Энэхүү хуулийн хэрэгжилтийн явцад аж ахуйн нэгжүүдэд үүсэх зардал нь үндсэндээ хөрөнгө оруулалтын шинжтэй бөгөөд урт хугацаанд дараах эерэг үр дүнг бий болгоно:

- Хангамжийн тогтвортой байдал нэмэгдэнэ.
- Аюулгүй ажиллагаа, чанарын стандарт сайжирна.
- Санхүүгийн сахилга, тайлагналын ил тод байдал нэмэгдэнэ.

4. Иргэнд үүсэх зардал:

№	Зардлын төрөл	Хаана, ямар аж ахуйн нэгжид	Урьдчилсан зардал (сая ₮)	Юунд зориулагдах вэ / Үндэслэл
1	Шатахууны богино хугацааны үнийн өсөлт	Ерөнхий хэрэглэгчид	0% өсөлт (түр хугацаанд)	Нөөц бүрдүүлэх үед өртөг өсөх боловч дунд хугацаанд тогтворжино.
2	Хэрэглээний үнийн түвшний өөрчлөлт	Өрх, автомашин эзэмшигчид	0%	Шатахууны үнийн хэлбэлзэл богино хугацаанд нөлөөлнө.
3	Тээврийн үйлчилгээний зардал	Зорчигч, хэрэглэгч	0% өсөх	Түлшний өртөгтэй уялдан богино хугацаанд өсөх боломжтой.
4	Ил тод мэдээллийн хүртээмж	Бүх иргэн	0 ₮ (ашигтай нөлөө)	Үнийн, нөөцийн мэдээлэл ил тод болно.
5	Нийгмийн хамгааллын дэмжлэг	Эмзэг бүлэг	0 ₮	“Буфер дэмжлэгийн сан”-гаар үнийн хамгаалалт үзүүлнэ.
6	Ажлын байр, орлого	Нийт иргэд	Ашигтай (+)	Нөөц, хяналт, дэд бүтцийн төслүүдээр шинэ ажлын байр бий болно.
			Нийт: Шууд зардлын өсөлт 0%, урт хугацаанд тогтворжино.	Эерэг нөлөө давамгайл.

Өгөгдсөн хүснэгтэд Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, статистик мэдээлэл, *Салбарын тоон мэдээлэл, сая ам.доллар*

Үзүүлэлтүүд	2021	2022	2023	2024	2025 оны 10 сарын байдлаар
Нийт импорт* /А-80, Аи-92,95,98 автобензин, дизель түлш/	1,5 сая тонн	1,6 сая тонн	2,0 сая тонн	2,6 сая тонн	2,2 сая тонн
Хувь					
ДНБ-д эзлэх хувь	2.69%	2.61%	2.28%	0.96%	0.94%
Ажиллагсдын тоо	9074	9065	9076	9030	8979
Нийт ажиллах хүчинд эзлэх хувь	0.67%	0.67%	0.71%	0.72%	0.71%
Салбарын нийт зарлага**	1,008.4 сая ам.доллар	1,643.0 сая ам.доллар	1,632.0 сая ам.доллар	1,926.2 сая ам.доллар	1,574.4 сая ам.доллар
Нийт төсвийн зарлагад эзлэх хувь	-	-	-	-	-
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	-	-	-	-	-
Нийт улсын төсвийн хөрөнгө оруулалтад эзлэх хувь	-	-	-	-	-
Гадаад зээл, тусламж	-	-	-	-	-
Гадаад зээл, тусламжид эзлэх хувь	-	-	-	-	-
Салбарын бусад тоон статистик	-	-	-	-	-

Тайлбар:

* Стратегийн бүтээгдэхүүн (шатахуун)-ий нийт импортын хэмжээ

**Стратегийн бүтээгдэхүүн (шатахуун) худалдан авах нийт зардал

ДҮГНЭЛТ

Энэхүү Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төр, аж ахуйн нэгж, иргэнд үүсэх зардлыг тодорхойлсон бөгөөд хуулийн төсөл нь газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах, Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилготой.

Үүнтэй холбоотойгоор төр, хувийн хэвшил болон иргэдэд үүсэх зардлыг төрөл тус бүрээр тооцоолсноор, төрийн байгууллагын хувьд хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн нэгдсэн систем болон хяналт-шинжилгээ хийх, сургалт зохион байгуулах, ил тод байдал, эрсдэлийн “буфер” сан бүрдүүлэх зэрэг зардлыг 2025-2030 онд үе шаттайгаар улсын төсөв, Монголбанк болон олон улсын эх үүсвэрээр санхүүжүүлэх боломжтой гэж үзсэн.

Мөн хуулийн этгээдэд 30-45 хоногийн шатахууны нөөц бүрдүүлэх хөрөнгө оруулалт, мэдээллийн системд холбогдох техникийн зардал, стандарт, чанар, аюулгүй ажиллагааны шинэчлэл, сургалт, аудит, даатгалын зардал, зээлийн хүүгийн зардал зэрэг нь урт хугацаанд хангамжийн тогтвортой байдал, чанарын сайжруулалт, санхүүгийн сахилга бий болгох хөрөнгө оруулалтын шинжтэй гэж үзсэн.

Үүнээс гадна иргэдэд үүсэх нөлөө нь шууд мөнгөн дарамт бага боловч шатахууны үнийн тогтвортой байдал, хомсдол гарах эрсдэл буурах, эдийн засгийн тогтвортой байдал нэмэгдэх эерэг үр нөлөөтэй гэж үзсэн.

Хуулийг хэрэгжүүлснээр шатахууны хангамжийн тасалдал 60-70 хувь буурч, шатахууны нөөцийн хоног 30-аас 45 хоног хүртэл нэмэгдэж, санхүүжилтийн дэмжлэгээр аж ахуйн нэгжүүдийн дарамт, үнийн хэлбэлзэл, нийлүүлэлтийн эрсдэл бодитой буурч, иргэдийн амьжиргаанд эерэг нөлөө үзүүлнэ.

Өөрөөр хэлбэл энэхүү хуулийн хэрэгжилт нь тодорхой хэмжээний эхний хөрөнгө оруулалт шаардах ч дунд болон урт хугацаанд эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, шатахууны хангамжийн тогтвортой байдлыг бий болгох стратегийн ач холбогдолтой төсөл гэж дүгнэсэн.

---oOo---

САНАЛЫН ТОВЬЁГ

№	Санал өгсөн байгууллага	Яамдаас ирүүлсэн саналын огноо, дугаар	Ирүүлсэн санал	Тайлбар
1	Монголын газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын мэргэжлийн холбоо, Монголын нефть, хийн үндэсний ассоциаци	2025.11.12, №03	1.Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа, манай гол бэлтгэн нийлүүлэгч ОХУ болон Олон улсын улс төр, эдийн засгийн нөхцөл байдал тогтворгүй, урт хугацаанд үргэлжлэх төлөвтэй байгаа энэ цаг үед газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байлгах, нөөц бүрдүүлэхэд чиглэсэн төрийн дэмжлэг, зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна. 2.Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн “7.1.4. энэ хуулийн 7.1.3-т заасан чиг үүргийн хүрээнд импортын бүтээгдэхүүнийг хуваарилах, жижиглэнгээр түгээх, борлуулах хэмжээг тогтоох” гэснийг хасах саналтай байна. Энэхүү зохицуулалт нь зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг хязгаарлах, улмаар аж ахуйн нэгжүүдийн дотоод зохион байгуулалт, хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. 3.Дээрх 7.1.4 дэх заалтаас бусад хуулийн төслийн зүйл заалтуудыг бүрэн дэмжиж байна.	1.Дэмжсэн. 2.Саналыг хүлээн авах боломжгүй. 3.Дэмжсэн



МОНГОЛЫН ГАЗРЫН
ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН
ИМПОРТЛОГЧДЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО

Хаяг: УБ хот, СБД, 8-р хороо,
Юу Би Гранд Хотел,
16 давхар 1602 тоот
Утас: 976+771 99 771



МОНГОЛЫН НЕФТЬ,
ХИЙН ҮНДЭСНИЙ
АССОЦИАЦИ

Хаяг: УБ хот, СБД, 2-р хороо,
Сөүлийн гудамж 10/1, Твин Таур-2,
6 давхар, 604 тоот
Утас: 95010157

2025 оны 11 сарын 12-ны өдөр

№ 03.

Улаанбаатар хот

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМАНД

Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай


Газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын мэргэжлийн холбоо болон Монголын нефть, хийн үндэсний ассоциаци нь Монгол Улсын Засгийн газар, салбарын яам болон бусад төрийн байгууллагуудтай Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг тогтвортой байлгах, нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, тээвэрлэх, хадгалах нөхцөл, технологийг шинэчлэх бодлого, зохицуулалтын талаар урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн.

Танай яамнаас ирүүлсэн Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна.

1. Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа, манай гол бэлтгэн нийлүүлэгч ОХУ болон Олон улсын улс төр, эдийн засгийн нөхцөл байдал тогтворгүй, урт хугацаанд үргэлжлэх төлөвтэй байгаа энэ цаг үед газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байлгах, нөөц бүрдүүлэхэд чиглэсэн төрийн дэмжлэг, зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна.
2. Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн "7.1.4.энэ хуулийн 7.1.3-т заасан чиг үүргийн хүрээнд импортын бүтээгдэхүүнийг хуваарилах, жижиглэнгээр түгээх, борлуулах хэмжээг тогтоох" гэснийг хасах саналтай байна. Энэхүү зохицуулалт нь зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг хязгаарлах, улмаар аж ахуйн нэгжүүдийн дотоод зохион байгуулалт, хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.
3. Дээрх 7.1.4 дэх заалтаас бусад хуулийн төслийн зүйл заалтуудыг бүрэн дэмжиж байна.


МОНГОЛЫН НЕФТЬ ХИЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИЙН
ТЭРГҮҮН

Ц.МАЙДАР



ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН
ИМПОРТЛОГЧДЫН МЭРГЭЖЛИЙН
ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Л.ГАНБОЛД



**СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХАНГАМЖ,
НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ УЛСЫН ИХ ХУРЛААР
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

2025.11.25

Д/д	Овог нэрс	Албан тушаал	Утасны дугаар
1	Гонгорын Дамдинням	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	99116627
2	Атарбаатарын Энхжин	Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал	99117224
3	Чулууны Хишигдалай	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга	99197637
4	Туулхангайн Ганбаатар	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Гэрээ эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга	99990919
5	Пүрэвжавын Баянбаатар	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	99081694
6	Даваахүүгийн Даваабаяр	Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн дарга	99177206